

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, Лхагва гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

*Хуралдааны товч тэмдэглэл:* 1-3

*Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:* 4-42

---

<i>1. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	4-13
<i>2. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	13-24
<i>3. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төсвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл</i>	24-42

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Төрийн байгуулалтын байнгын хорооны  
12 дугаар сарын 20-ны өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 49 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Г.Ганболд, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Сүхбаатар;  
Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.

**Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Т.Доржханд, Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

**Н.Энхболд:** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 17 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж, Т.Доржханд нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ж.Батсуурь, Д.Тогтохсүрэн нар үг хэлэв.

**Н.Энхболд:** “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 14  
Татгалзсан: 0  
Бүгд: 14  
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн А.Адъяасүрэн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төсвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Ажлын албаны дарга Д.Баяндүүрэн, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Сонгуулийн ерөнхий хорооны дэргэдэх Мэдээллийн

технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт А.Банзрагчдорж нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт А.Наранцэцэг, Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Байнгын хорооны дарга Н.Энхболд “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төсвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Б.Пүрэвдорж, Т.Доржханд нарын тавьсан асуултад Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд, Сонгуулийн ерөнхий хорооны дарга П.Дэлгэрнаран, мөн хорооны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар, Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь, Т.Доржханд, С.Амарсайхан нар үг хэлэв.

**Н.Энхболд:** “Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнд нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн сонсголын тов, сонсгол даргалагчийг томилох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар санал хэлэв.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 6  
Бүгд: 14  
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 18 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 42 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 73.7 хувийн ирцтэйгээр 19 цаг 31 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:  
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 12 дугаар сарын 20-ны өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
16 цаг 49 минут.

### ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

**Н.Энхболд:** Төрийн байгуулалтын байнгын хорооны ирц бүрдсэн байна. Доржханд гишүүн, Оюунчимэг гишүүн, Тогтохсүрэн гишүүн, Жаргалмаа гишүүн, Энхболд гишүүн, Батсуурь гишүүн, Занданшатар гишүүн, Эрдэнэбат гишүүн, Бямбацогт гишүүн, Мөнх-Оргил гишүүн, Сарангэрэл гишүүн нар ирж, ирцдээ орсон байна. Адъяасүрэн гишүүнийг дуудъя, Ганболд гишүүнийг дуудъя, Г.Мөнхцэцэг гишүүнийг дуудъя, Сүхбаатар гишүүнийг дуудъя, Амарсайхан гишүүнийг дуудъя, Пүрэвдорж гишүүнийг дуудъя. Хуралдааны ирц бүрдсэн учраас ТББХ-ны 23 оны 12 сарын 20-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслүүдийг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Хуралдаанд ажлын хэсгийг урья. СЕХ-ны дарга Дэлгэрнаран, СЕХ-ны

гишүүн, Ажлын албаны дарга Баяндүүрэн, дуудаарай цаанаасаа. СЕХ-ны Хууль, эрх зүйн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ, СЕХ-ны Дэргэдэх Мэдээллийн технологийн төвийн Техник хангамж, засвар үйлчилгээний төвийн референт Банзрагчдорж нарыг дуудаж байна. Тийм заримыг нь шинэчилж бариад яачихсан тийм, нөгөө компаниас. Хэлэлцэх асуудалдаа оръё.

### Нэг. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн нэгд Улсын Их Хурал төрийн дотоодод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараах асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ гэж заасан байгаа. Ерөнхийлөгчийн, Улсын Их Хурал түүний гишүүний сонгуулийг товлон зарлах энэ асуудал байдаг. Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9.1-д ээлжит сонгуулийг сонгуулийн жилийн 2 сарын 1-ний өдрөөс өмнө товлон зарлаж, санал авах өдрийг тогтооно. Ээлжит сонгуулийн санал авах өдөр нь ээлжит сонгуулийн жилийн 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр байна. Гадаад улсад байгаа иргэдээс санал авах өдөр, өдрийг сонгуулийн төв байгууллагын саналыг үндсэн Улсын Их Хурал тогтоох бөгөөд гадаадад санал санал авах өдөр нь 4 хүртэл өдөр байна гэж заасан байгаа.

Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хурал хуульд шийдвэр гаргахаар хууль тогтоомжид заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон аливаа зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцээд санал, дүгнэлт шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна гэж заасан байгаа. Ер нь болбол өнөөдрийн бид нарын

хэлэлцэх гэж байгаа асуудал бол Үндсэн хууль, Их Хурлын тухай хууль, Сонгуулийн тухай хуультай холбоотой ийм агуулгын хувьд ийм асуудлууд байгаа. СЕХ-ноос бас холбогдох зарим судалгаа саналуудыг авсан байгаа. Би тогтоолын төсөл төслийг эхлээд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын 24 оны ээлжит сонгуульд товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай тогтоолын төсөл. Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгууль товлон зарлах, санал авах өдрийг тогтоох тухай. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2, 9.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 2024 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэхээр товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн санал авах өдрийг 2024 оны 6 дугаар сарын 28-ны өдөр байхаар тогтоосугай.

3. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар гадаад улсад байгаа иргэдээс авах санал авах өдрийг 2024 оны 6 дугаар сарын 20, 21, 22, 23-ны өдрүүд байхаар тогтоосугай.

4. Энэ тогтоолыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй гэсэн тогтоолын төсөл байна. Гадаадад байгаа иргэдээс санал авах өдрийн талаар төрийн байгуулалтын юу, ТББХ-ноос хорооноос явуулсан бичгийн дагуу СЕХ саналаа ирүүлсэн. Ингээд 6 сарын 20, 21, 22, 23-ны өдөр саналыг нь авъя гэсэн ийм саналаа ирүүлсэн. Энэ ажлыг болбол

СЕХ, ГХЯ хамтраад зохион байгуулах ёстой. Тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух гишүүн байна уу? Батсуурь гишүүнээр, Пүрэвдорж гишүүнээр тасаллаа. Занданишатар дарга.

**Г.Занданишатар:** Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Ажлын хэсэгтэй нэг холбоотой асуулт байна. Энэ гадаад улсад байгаа иргэдийн санал авах өдрийг 6 сарын 26-наар тооцоод 20, 21, 22, 23 гээд тэгчихсэн юм шиг байх юм. Тэгээд ер нь яах вэ өмнөх сонгуулиуд 3 дахь өдөр явж байсан ирцээ тэгээд тооцчихсон байна уу? Энэ чинь сонгуулийн өдрийн хуваариар харах юм болбол 28-тайгаа уялдах уу? Ирүүлэх, буцах энэ чинь бас нэг зай чөлөө чинь болбол нэг их гарах ёсгүй шүү дээ тийм ээ? Энэ асуудлыг 20-нд аваад эхэлчихээр 28-нд болох гэж байгаа сонгуулийг 20-нд авах гээд байна шүү дээ. Тэгээд энэ 26-нд хийх учир шалтгаан юу байна энийг 1 дэх асуулт.

2 дугаарт нь энэ АН-ын бүлгээс санал тавиад байгаа юм байна. Батсуурь дарга албан ёсоор санал гаргах ёстой юм уу? Сонгуулийн бүртгэлийн асуудал байна шүү дээ. Тэрүүгээр нэг намуудын нэг бие даасан нөгөө бүртгэл дээр л хүн амьтан бүртгэлтэй, бүртгэлгүй байна гээд л нэг хэл ам гардаг шүү дээ тийм ээ. Тэрнийг цэгцлэх хянах зорилготой нэг ажлын хэсэг ажиллуулъя гэж. Дэд, энэ тогтоол тусгаад нэг дэд хорооны дэргэд нэг тийм юу ажлын хэсэг маягтай юм байгуулъя гээд байсан юм. Тэрнийг тогтоол дээр тусгая гэсэн санал танай дарга нар яриад байсан юм. Цогтгэрэл дарга, энэ дарга нар эртээдийн уулзалт дээр. Энийгээ тусгах ёстой юм уу, үгүй юм уу? Тийм бол танай нам санал гаргах ёстой юу? Энийгээ нэг тодруулчихъя.

**Н.Энхболд:** Дэлгэрнараран дарга 4 дүгээр микрофон, хойшлуулж болох уу гэсэн утгаар асуулаа гэж, дунд нь гадаадаас санал авсан өдөр, энд санал хураах өдөр 2-ын хоорондох зайны



асуудал. Тэгээд аль өдрүүдийг тохирсон,ы 26 гэж бодоод ингээд хийчихсэн юм биш биз дээ гэж бас асуугаад байна. 4 номер.

**П.Дэлгэрнаран:** Би даргын асуултад хариулъя. Ер нь бид нар болбол гадаадад байгаа иргэдийн санал авах өдрийг 20, 21, 22, 23 гээд ингээд 4 өдөр 5 дахь өдөр, эхлээд 1 дэх өдөр дуусахаар. Тэгээд үндсэн санал хураалтын өдрийг болбол 6 дугаар сарын 26 гэж тооцож санал өгсөн. 26 гэж тооцдогийн гол агуулга нь болохоор 26 гурав дахь өдөр, тэгээд 6 дугаар сарын хамгийн сүүлчийн 7 хоног явж байгаа. Тэгээд энэ үед болбол ид зун болсон, аялал зугаалгын ажил эхэлсэн үе. Тэгээд сонгууль маань болбол ирцтэй тэгээд 5-д, 28 гэхээр бол 5 дахь өдөр байгаа. 5 дахь өдөр болбол хүмүүс дараагийн үргэлжлэх амралтын өдрүүдтэй нийлүүлээд, тэгээд тэр чинь нөгөө өдөр уртассан зуны цаг болсон учраас бүүр бид нарын нөгөө саналаа өгөөч гэж чөлөөлж өгсөн өдрийн маань бүүр аялал зугаалгын өдөр болгоод ашиглачих вий, бүүр 4 дэх өдрийн орой аялал зугаалгын ажил нь эхлээд ингээд нөгөө саналын саналаа өгөх ажил маань болбол өөр зориулалтаар ашиглагдах вий гэсэн болгоомжлол байгаа юм. Тийм учраас бид нар болбол санал хураалтад зориулж ажлын өдрийг чөлөөлж байгаа юм чинь энэний дараагаар болбол 2 ажлын өдөр байвал хүмүүс болбол ямар нэг хэмжээгээр энийг болбол ашиглаж ийш тийшээ гадагшаа дотогшоо хөдөө гадаа явах нь арай гайгүй болов уу гэсэн тооцооллоор 26-ны өдөр буюу лхагва гарагт хийе гэсэн хийх юм, хийвэл боломжтой юм гэж СЕХ уг нь санал гаргасан юм. Тэгээд энэ урьд нь болсон сонгуулиуд мөн ялгаа байхгүй дандаа 3 дахь өдрүүдэд явж байсан ийм уламжлалтай учраас ингээж хийх юм болов уу гэж.

Гадаад авах, гадаадад байгаа иргэдийн саналыг авах хугацаа дээр болбол ерөнхийдөө бол энэ хугацааг болбол улс санал хураах өдрийг бол Улсын

Их Хурал тогтоох учраас 26-нд ч байсан, 28-нд ч байсан энэ өдрүүд болбол өөрчлөгдөхгүй байж болох юм гэж үзэж байгаа юм.

**Н.Энхболд:** Баярлалаа. Тэр бүртгэлтэй холбоотой асуудал яг энэ тогтоолтой холбогдож яригдахгүй. Ер нь болбол манай дэд хэсэг дэд хороо байгаа, СЕХ эд нар тэрүүгээрээ яриад шийдчих болов уу гэж бодож байна. Доржханд гишүүн асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр Улсын Их Хуралд суудалтай намуудын удирдлагууд бас энийг зөвшилцсөн байгаа. Тэгээд бидний хувьд бол энэ санаачилгыг бол маш их дэмжиж байгаа. Ялангуяа Монгол Улсын эдийн засагчид бол бүүр их дэмжиж байгаа. Монгол Улс хөгжихгүй байгаа шалтгаан нь юу байна гээд тэгэхлээр маш олон жижижсэн тойрог дагасан төсвийн санхүүжилт байдаг. Энэ чинь юуных билээ, тийм үү? Ойлголоо. Тэгвэл тов дээр нэг л асуулт байна л даа. Энэ гадаадад байдаг, гадаадад байдаг иргэд маш их холбогддог юм. Тэгээд тэд нар маань нөгөө олон хотоос ингээд тухайлбал нөгөө саналаа өгөхийн тулд нисэж ирдэг, галт тэргээр ирдэг, тэгээд автобусаар ирдэг, машинаар ирдэг. Тэгээд нөгөө ажил нь өөрөө ингээд боломжгүй байдаг тийм ээ. Тэгээд тийм болохлоор аль болох л нөгөө олон хоног ингээд тавьж өгөөч бид нарт. Яагаад гэвэл энэ чинь пропорциональ элемент орчихсон байгаа, нийт саналын маань 48 нь пропорциональ буюу гадаадад байдаг иргэд одоо сонгуульд оролцох боломжтой болчихсон. Яг Ерөнхийлөгчийн сонгуультай адилхан тийм биз. Тэгээд түүнтэй холбоотойгоор 1 дүгээрт энэ өдрөө ингээд уужуу тавьж өгөөч гэж байгаа юм. Олон хоногоор тавьж өгөөч, боломжтой тавьж өгөөч гээд.

Тэгээд 2 дугаарт бол нөгөө сонгуульд оролцох тэр нөгөө ажлын цаг гээд л тухайлбал өглөө 8-аас тэд гээд л тэгдэг шүү дээ тийм ээ, 5 ч гэдэг юм уу.

Тэрийгээ ингээд орой 10 цагаар ч байдаг юм уу уртасгаж өгөөч гэдэг санал гарч ирдэг юм. Тэгээд энэ дээр та бүгд маань яг энэ дээр төлөвлөсөн ажил байна уу, тэгээд өдрийг нь ингээд өсгөх боломж байна уу гэдэг дээр нэг хариулт авъя. Баярлалаа.

**Н.Энхболд:** Дэлгэрнарэн гишүүн тэр сонгуулийн хэдэн цагаас хэдэн цаг хүртэл санал хураах асуудлын зохицуулалтын талаар тайлбарыг нь хэлчээрэй. Эхний асуултын хувьд бол ийм Доржханд гишүүнээ. Сонгуулийн тухай хуулиар дээд тал нь 4 өдөр гээд заачихсан юм. Бид нар дээд хэмжээгээр нь л авч байгаа. Урьд нь 3 өдөр энэ тэр байсан. Тэгээд энэ удаа 4 өдөр хуульд заасан дээд хэмжээгээр нь аваад, тэгээд энэ өдрүүдийг заадаг нь ямар учиртай юм бэ гэхээр хагас сайн, бүтэн сайн бас тэр хүмүүсийн хувьд аль болохоор ажил төрөл нь илүү бололцоотой байх үеүдийг сонгоод, энэнээс урагшлуулчих гэхээр сурталчилгаа дуусаагүй байгаа үед саналыг нь авч болохгүй. Тэгж ярьж байгаад л 20, 21, 22, 23 гэдгээрээ тавьсан байгаа юм. Дэлгэрнарэн дарга тэр сонгуулийн санал авах өдрийн цагийн зохицуулалтын талаар тайлбар хэлчихье.

**П.Дэлгэрнарэн:** Цагийн зохицуулалтын хувьд болбол яг адилхан энэ үндсэн санал хураалт болох өдөр, хураалтын хугацаатай адилхан өглөө тухайн улсын өглөөний 7 цагаас 22 цаг хүртэл байхаар байгаа. Тэгээд 4 өдөр үргэлжилнэ. 4 өдөр бол яг хууль дээр зааснаараа бол 4 өдөр хүртэл гэж байгаа. Бид нар болбол яг бүтэн 4 өдрөөр нь авъя гэж байгаа юм. Аль болохоор гадаадад байгаа иргэдийн саналыг өгөх боломжит хугацааг уртасгахын тулд 4 өдрийг бол бүтэн ашиглая гэсэн ийм саналтай байгаа.

**Н.Энхболд:** Батсуурь гишүүн асууя.

**Ж.Батсуурь:** Үндсэн хууль, шинэ Үндсэн хуулиас хойш 9 дэх удаагийн сонгууль болох гэж байна. Олон удаагийн сонгуульд олон л янзаар орж байсан. Тэгээд анх удаа энэ пропорционалийн элемент орж ирж байна. Дээр нь 126 гишүүнтэй болж, жагсаалт тойргийн систем 2 хосолж байна. Дээр нь ахиад томсгосон байдлаар бүсчилж орж ирж байна. Тэгээд энэ дээр тов тогтох гэж байгаа асуудлууд дээр энэ хугацаандаа ер нь амжих юм уу 1 дүгээрт? 1 өдрийн хугацаанд ер нь миний ойлгож байгаагаар энэ чинь ингээд 10 мандаттай тойрог 10 нам нэр дэвшүүлье гэх юм бол 100 хүнээс 10-ыг сонгох нь байна шүү дээ, 100 хүнээс. Тийм учраас ингээд нэг хар юм руу хийдэг. Эндээс 100 хүнээс өөрийнхөө 10-ыг түүх гэсээр байтал 1 дүгээр асуулт.

2-т нь 9-ийг сонговол яах вэ, 10 мандаттай тойрог дээр, 11-ийг сонговол яах вэ гэсэн 2 дугаар асуулт байна.

3-д нь энэ тогтоолын нэг дэх заалт дээр Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийг 1 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн товлон зарласугай гэж. Тэгэхээр нөгөө Сонгуулийн хууль дээр Сонгуулийн хууль товлон зарласан өдөр хүртэл гээд нөгөө нэг бэлэг сэлт уулзалт гээд нэг хязгаарласан хугацаа байдаг. Тэр 23 оны 12 сарын 31-нээр дуусах гэж байна уу, 24 оны 1 сарын 31-нээр дуусах гэж байна уу гэсэн асуулт байна.

Дээр нь энэ тогтоолын 3 дугаар заалт дээр гадаад улсад байгаа иргэдээс авах санал гэдэг чинь гадаадад байгаа хүн чинь аль ч хамаагүй тойргийн Монгол хүндээ өгөх юм уу, өөрийнхөө харьяалах тойргийн хүндээ өгөх юм уу гээд. Ер нь бол зөвхөн тов зарлаад хаячих орхичихоосоо гадна энэ дараагийн тогтоолууд дээр яригдах байх л даа. Ийм олон асуудлууд байгаа. Тэгэхээр хамгийн эхлээд техникийн боломж талаас нь авхуулаад саяын 4 асуултад харуу



*авчхаад би дахиж тодруулъя гэж бодож байна.*

**Н.Энхболд:** *Техникийн боломжийнхоо асуудлаас эхлээд эхэлье. Дэлгэрнараран дарга, өөр танайхаас хэн нь вэ? 1 дүгээр асуулт асуултад хариулъя.*

**П.Дэлгэрнараран:** *Бид нар саналын хуудсыг ерөнхийд нь бол төсөөлөл маягаар хийж үзэж байгаа, судалж байгаа. Тэгээд саналын хуудсан дээр болбол ер нь нэг тойрог бүсчилсэн байдлаар тойргийг байгуулбал нэг тойрогт болбол нэг 10-аад мандат байна. 37 улс төрийн нам бүртгэлтэй байгаа. Эндээс хэд нь их идэвхтэй бүрэн хэмжээгээр дэвшүүлж болох вэ энэ тэр гээд бид нар бол судалгааны ажлуудыг бол хийж байна. Тэгээд хуучин явж байсан тойргуудаасаа болбол ингээд бүсчилсэн хэлбэрээр яахад саналын хуудасны хэмжээ бол томорно, тэр бол томорно. Тэгээд энэ дээр болбол бас нэг жаахан хүндрэл үүсэж болзошгүй зүйл болбол сонгогчид саналаа өгөхдөө бол жаахан төвөгшөөлтэй ойлгохгүй хүндрэл үүсэх ийм магадлалтай. Тийм учраас болбол энэ сурталчилгааны ажлыг болбол сайн хийж өгөх ёстой, саналаа өгөх арга зөвлөмжүүдийг бол бид нар сайн хийж өгөх хэрэгтэй гэж үзэж байгаа.*

*Техникийн хувьд болбол боломжтой. Энийг бол бид нар болбол одоогийн манай хэрэглэж байгаа техникүүд болбол бүгд бэлэн болсон байгаа. Одоо энэ туршилт шалгалтын ажлууд бол бүгд хийгдэж байгаа. Тэгээд техникийн хувьд болбол боломжтой гэж үзэж байна. Зүгээр яах вэ санал авах хугацаа бол жоохон уртасна. Тэгээд процесс маань жаахан удааширалтай явах учраас. Тэгэхээр бид нар болбол олон сонгогчидтой хэсгүүдийн хороод дээр болбол 2 төхөөрөмжийг зэрэгцүүлж тавьж ажиллуулах ийм ажлуудыг хийнэ гэж тооцоолж байгаа.*

**Н.Энхболд:** *Баярлалаа. Дараагийн асуулт нь та асуусан тэр мандатын тоогоор байх уу, дутуу байвал яах вэ заавал гүйцээх үү гэж. Сонгуулийн тухай хуульд мандатын тоотой тэнцүү хэмжээний санал өгнө гээд биччихсэн байгаа. Дутуу байвал хүчингүй болно. Энэ нэг хариулт нь. Гадаадад байгаа улсууд аль ч хамаагүй өөрийнхөө хүссэн тойрогт саналаа өгөх үү, яаж өгөх юм бэ гэж. Гадаадад байгаа иргэд болбол зөвхөн жагсаалтад саналаа өгнө. Тойрогт хуваагдаж хуваагдах боломжгүй учраас, оршин сууж байгаа газар нь өөр байгаа учраас энэ байна. Нэг өдөр байх юм уу, нэг өдөр ч хүрэлцэхгүй юу гэсэн утгатай асуулт байсан. Хуульд Улсын Их Хурлын сонгуулийн санал хураалтыг 6 дугаар сарын сүүлийн хагасын аль нэг ажлын өдөр гээд ингээд хуулиараа бид нар батлаад гаргасан хуулиараа заачихсан. Тэгэхээр ёстой Дэлгэрнараран даргын хэлж байгаа шиг сурталчлах, таниулах тэр олон нэрс нэрстэй жагсаалтууд байвал зэрэг, зэрэг машин тавих тийм ээ, тэгээд хамгийн гол нь бүгдээрээ төрийн байгууллагууд ч тэр, улс төрийн намууд ч тэр хүмүүсээ эртнээс их бэлтгэлтэй байж сонголт, ер нь хүмүүс сонголтгоо нэлээд хэсэг нь эрт хийчихдэг дээ. Түүнээс яг сонгуулийн өдөр оччихоод л тэр олон нэр дотроос аль нь гээд суугаад байх нь юу л бол гэж боддог юм. Тэгэхээр сонгуулийн хороо, хэсгийн хороод тэгээд бүгдээрээ энэ сурталчлах ойлгуулах энэ юмнуудаа их сайн хийх шаардлагатай болно байх гэж бодож байна. Батсуурь гишүүн.*

**Ж.Батсуурь:** *Туршиж байгаа л гэж байна. Туршилтад л Монголчууд чинь явчхаад байгаа шүү дээ. Нүүрснээс авхуулаад л бүх л юмыг туршаад байдаг, яасан ч туршиж дуусдаггүй юм. Тэгэхээр тойрог дотор шилжих үү? Ингээд баруун 5 аймаг баруун 4 аймаг нийлж байна. Завханаас Ховдод сурталчилгаа хийж байгаа хүн Завхан дээрээ санал өгөх үү, тойргийнхоо аль ч аймагт тэр чинь өөрийнх нь сонгох тойрог нь тодорхой байна шүү дээ өгөх үү? Тэгээд*

энийг яаж хязгаарлах юм бэ? Энэ чинь өөрөө нөгөө царцааны чинь асуудлыг царцаа гээд нэг хэсэг ярьдаг байсан, ингээд нэг сонгуулийн хууль болохоор нэг хэдэн моод болсон үгнүүд байдаг шүү дээ. Царцааг чинь харин царцаа чинь бол хуучин жижиг тойрогт бол байдаггүй байсан юм шүү дээ. Хүнээ таньдаг. Жишээлбэл манай сумд шинэ хүн ирчихсэн байна, манай аймагт шинэ хүн ирчихсэн байна гээд ингэдэг. Тухайн.../минут дуусав/

**Н.Энхболд:** Асуултаа гүйцээчих Батсуурь гишүүнээ.

**Ж.Батсуурь:** Тэгэхээр энэ томсгосон тойрог дээр бол царцаа чинь хяналтаас гарах юм биш үү. Тийм учраас энийг яаж шийдье гэж байгаа юм бэ гэсэн энэ асуулт байна. Дараа нь нөгөө сөрөг хүчинд олдож байгаа хоёрхон боломж байдаг. Нэг нь Төсвийн хяналтын дэд хороо, нөгөөдөх нь Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэлийн хяналтын дэд хороо гэж. Тэгэхээр энэ үйл ажиллагааг бол зөвхөн дарга томилоод л орхичихсон. Тэгэхээр энэ тойргийн системд орж байгаа 126 хүн нэр дэвшиж байгаа 78 мажоритар байгаа энэний бүх асуудлыг шийдэхэд бол энэ Их Хурлын байгууллага дэд хороо дээр нэлээд асуудлууд шийдэгдэх байх л даа. Тийм учраас энийг Ажлын албатай болох, орон тоо бүхий энэ ажиллах боломжоор нь хангах тогтоолыг сая Энхболд гишүүн энэ тогтоол дээр ярихгүй, өөр ярина гэсэн. Хэзээ ярих юм, ямар тогтоол дээр ярих юм бэ? Энийг яг энэ хууль эхэлсэн өдрөөс нь авхуулж Ажлын албатай болгож ажилд нь оруулахгүй бол зөвхөн Сонгуулийн хороо бол сонгуулийнхаа ажлыг хийгээд явчихна. Иргэний бүртгэл иргэний бүртгэлийнхээ ажлыг хийгээд явчихна. Тойргууд тойргийнхоо ажлыг хийгээд явчихна. Тэгэхээр энийг энэ бүгдийг Их Хурал хяналтдаа байлгаж, цэгцэлж, болохгүй зүйлийг нь урьдчилан мэдэж, сануулж, сургалт семинар хийхээс авхуулаад судалгаа тооцоо хийхээс

авхуулаад гадаад дотоодын бусад энэ том нутаг дэвсгэртэй цөөн хүн амтай газар яаж хийдэг юм, мөн пропорциональ мажоритар хосолсон үед яаж хийдэг юм гэдгийг бид нар анх удаа хийж байгаа учраас энэ Сонгогчийн нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хорооны ажлыг бол анх удаа харин нэлээн өргөн бүрэлдэхүүнтэй мэргэжлийн бүхий энэ Ажлын алба байгуулж өгөх асуудлыг тусгайлан хэлэлцэнэ гэсэн үү яана гэсэн энэ дээр нэг хариулт авчихъя.

**Н.Энхболд:** Нэрсийн жагсаалт, сонгогчдын бүртгэл, нэрсийн жагсаалттай холбогдсон ажлын хэсгийг дэд хороог манай Батсуурь гишүүн ахалж байгаа. Ер нь урьд өмнөх практикаар бид нар энэ тогтоолууд батлагдсаны дараа яг энэ ажил эхэлдэг юм. Ажлын хэсэг байгуулна, бүрэлдэхүүнд нь дэд ажлын хэсэг байгуулна. Туслах гэсэн үг шүү дээ тийм ээ. Тэгээд энэ дээр болбол бүртгэлийн газар цахим энэ жилээс энэ Цахим хөгжлийн яам эд нар, тэгээд Улсын Их Хурлын Ажлын алба үндсэндээ энд бараг бүрэн дайчлагдаад ордог ийм. Тэгэхээр энэ хийгдэж байсан ажил энэ тогтоолууд батлагдсаны дараа таны яриад байгаа энэ зүйлүүд нэмэгдэнэ, хийгдэнэ. Тэр юун дээр Дэлгэрнарар дарга нөгөө юу хоорондын, Бат-Эрдэнэ үү? 1 номерын телефон, царцаа, биеийн давташгүй үзүүлэлт тийм, тойрог дотроо яаж зохион байгуулах вэ? Завханы хүн Увсад очоод санал өгч болох уу?

**Д.Бат-Эрдэнэ:** СЕХ-ны Хуулийн хэлтсийн дарга Бат-Эрдэнэ. Батсуурь гишүүний асуултад хариулъя. 2020 оны Улсын Их Хурлын сонгуулиас хойш бол сонгох сонгуулийн дүнд нөлөөлөхүйц хэмжээгээр сонгогчийн шилждэг энэ байдлыг бол таслан зогсоосон, хуулиар хориглосон байж байгаа. Хуульд хэн шилжиж болох вэ гэдгийг маш тодорхой заасан. Энд болбол сонгуулийн байгууллагад ажиллаж байгаа төрийн

албан хаагчид, хамгаалалтад ажилладаг цагдаа нар, нэр дэвшигч болон нэр дэвшигчийн менежер, шадар туслагч гэсэн энэ хүмүүс л зөвхөн сонгогчийн шилжилтийг хийлгэж, тухайн байгаа газраа саналаа өгөх боломж нь бүрдэж байгаа. Хуучин болбол дуртай сонгогч нь дуртай газраа шилжээд саналаа өгдөг байсан. Энэ нь эргээд болбол магадгүй санал хураалтын дүнд сөргөөр нөлөөлөхүйц нөхцөл байдлыг бий болгож байна гэж үзсэн учраас хуульд энэ хориглолтыг хийж өгсөн.

Сонгогчдын нэрийн жагсаалтын хувьд болбол биеийн давхцалгүй өгөгдөл дээр үндэслэж үйлдэгддэг учраас эргээд сонгогч болбол 2 газар санал өгөх гэдэг юм уу ийм боломж бол бас хязгаарлагдмал, ийм боломж бол байдаггүй гэдгийг хэлэх байна.

**Н.Энхболд:** Нэг тодруулчих даа, микрофоныг нь Батсуурь гишүүнийг.

**Ж.Батсуурь:** Одоо энэ дээр жишээ аваад байна л даа. Хамгийн олон Ховд, Увс, Говь-Алтай, Завхан. Би 2 газар санал өгөх үү гэж асуугаагүй. Энэ чинь нэг тойрог болчих гэж байна шүү дээ. Ховд, Увс, Говь-Алтай, Завхан гээд. Тэгээд Завханы сонгогч Ховд аймагт явж байгаад тэнд сонгуулиа өгч болох уу? Яагаад вэ гэхээр нэг тойрог шүү дээ энэ чинь. Тийм.

**Н.Энхболд:** Оршин сууж байгаа газраа л өгч ирсэн, наадах чинь замбараагүй. Нөгөө нүүдэл шинжилгээнд чинь бас замбараагүй юм болно.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ, харин тэгэхээр 1 тойргийн ямар ялгаатай юм бэ? Сонгох хүн нь адилхан байна шүү дээ. Сонгох гэж байгаа тэр хүмүүс чинь адилхан байхад чи сонгох гэж байгаа хүнээ заавал тэндээс өг гэх юм уу, байгаа газраасаа өгөх юм уу гэсэн асуулт асууж байгаа байхгүй юу. 2, би давхардаж өгнө гэсэн байдал бол асуухгүй байна. Би аягүй ойлгомжтой асууж байна шүү дээ. Ховд,

Увс, Говь-Алтай, Завхан чинь ижил сонгогчийг ижил хүн сонгох гээд байгаа байхгүй юу. Гэхдээ чи Завханы бүртгэлтэй юм чинь Завханаасаа өгнө гэхэд.../минут дуусав/

**Н.Энхболд:** Бат-Эрдэнэ. Ямар ч тохиолдолд тийм юмнууд.

**Д.Бат-Эрдэнэ:** Тийм. Яг сонгогчийн шилжилт хөдөлгөөнөөр л зохицуулагдана л даа. Шилжилт хийлгэх боломжтой хүн нь зөвхөн төрийн албан хаагч болон нэр дэвшигч өөрөө, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч гэсэн хүмүүс. Бусад сонгогчийн хувьд болбол өөрийнхөө байнга оршин суугаа хаягийнхаа харьяа хэсэг дээр л саналаа өгнө.

**Н.Энхболд:** Пүрэвдорж гишүүн. Энийг хуулиар зохицуулчихсан шүү дээ Батсуурь гишүүнээ хуульд, оршин сууж байгаа газраа.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2020 оны сонгуулиар нийтдээ 29 нам байсан бүртгэлтэй. Яг энэ сонгууль 20 оны сонгуулиар бол 14 нам дангаараа, 3 эвсэл сонгуульд оролцсон байгаа. 17 субъект оролцсон гэсэн үг. Тэгэхээр өнөөдрийн байдлаар бол 39 намтай болчихсон, 37 намтай болчихсон байгаа. Үгүй ээ 37 намын миний тооцож байгаагаар бол 25, 20 орчим нам дангаараа ороод, тэгээд 5 эвсэл орох байх гэсэн ийм тооцоо байж байгаа. Тэгэхээр 2 том нам дээрээс нь парламентад суудалтай ХҮН нам энэ тэр бол нэлээн олон 10, 10 тэгээд ХҮН нам бол жишээ нь юу байдаг юм нэг хүмүүсийнхээ саналыг төвлөрүүлэхийн тулд 7, 8-ыг оруулдаг ч юм уу ингээд нэлээн олон ороод явчихна. Тэгээд дээрээс нь дахиад нөгөө үлдсэн 10 хэдэн 20--иод нам, эвслийнхэн чинь нийтдээ 6 хүнээр энэ чинь 39-өөс доошгүй хувьтай нэр дэвшүүлэх ёстой юм.

Тэгэхээр энэ тохиолдолд бол нэг миний тооцоогоор бол 100 хүн, 100 хүн л яах гээд 78 хүн бол бусад нам

парламентаас суудалтай бусад намууд 6 хүнийг дэвшүүлээ гэж үзэхэд жишээ нь, жишээ нь 10 тойруу мандаттай газар 6-г дэвшүүлээ гэж үзэхэд 100 орчим хүн л жишээ нь баруун 4 аймаг дээр нэр дэвшүүлэх нь л дээ. Тэгэхээр энэ дээр нөгөө машин яаж униших вэ? Энэний техникийн асуудлыг хэр зэрэг яаж шийдэж байгаа юм бэ? Тэгээд одоо ингээд наадах чинь гол асуудал юу байх вэ гэхээр нэг хуудсаар баахан нэрс бичдэг, тэр нь хэтэрхий жижигхэн байвал яаж вэ? Шрифт нь ямархуу байх юм бэ? Нөгөө ахмад настай хүмүүс тэрнийгээ харах боломж нь юу юм бэ? Тэгээд дээрээс нь тэр хэтэрхий жижигхэн дугуйлдаг байх юм болбол тэр юу нь тэр будгаараа будаж чадах уу гэдэг ийм асуудлууд байна.

2 дугаарт нь сүүлийн хэдэн сонгууль ерөөсөө дандаа 3 дахь өдөр явсан тэгээд 1 дүгээрт. 2 дугаарт гадаадынхан бол хагас сайн, бүтэн сайнд л завтай байдаг юм Энхболд даргаа. Тийм учраас би энэ ямар санал гаргаж байна вэ гэвэл энэ СЕХ-ны орж ирсэн, оруулж ирсэн 3 дахь өдөр сонгууль хийнэ гэдэг чинь зөв. Хэрвээ 5 дахь өдөр байх юм болбол бүх залуучууд 4 дэх өдрийн орой бүгдээрээ хөдөө явчихна, амраад явчихна, ашгүй зав гарлаа гээд. Тийм учраас энэ 3 дахь өдөр оруулдаг нь зөв. Тэгээд 6 сарын 22-ны хагас сайн, 6 сарын 23-ны бүтэн сайн, тэгээд дээрээс нь дахиад нэг өдөр буюу 1 дэх өдрийн 24-ний өдөр ингээд 3 өдөр гадаадын сонгогчдоосоо саналаа авчихъя. Тэгээд 26-ны өдөр уламжлалынхаа дагуу 3 дахь өдөр санал хураалтаа явуулъя л гэсэн ийм л санаатай байгаа юм. Энэ дээр ямар бодолтой байгаа юм бэ? Дээрээс нь Энхболд дарга бас яг энэ намынхаа байр суурийг яагаад ингэж 5 дахь өдөр болгосон юм бэ энэ талаараа бас нэг тодорхой яриадах даа.

**Н.Энхболд:** Дэлгэрнарэн дарга хариулъя. Техникийн бололцооныхоо талаар.

**П.Дэлгэрнарэн:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Саналын хуудсыг хуудасны хэмжээ зэрэг болох вэ, ингээд энэ одоогийн байгаа 37 бүртгэлтэй улс төрийн намаас болбол 20 гаруй субъект нь оролцоход тэгээд бүрэн хэмжээгээр дэвшүүлэхэд гэж. Тэгэхээр Улс төрийн намын тухай хууль саяхан батлагдаад тэгээд хэрэгжих хугацаа бол 24 оны 1 сарын 1-нээс. Улс төрийн намын хуулиар болбол Улсын Их Хурлын сонгуульд нам нэр дэвшүүлэхдээ 50-аас доошгүй хувийг хувьд нь мандатын 50-аас доошгүй хувьд нэр дэвшүүлж байж нэр дэвшүүлэх бүртгэх нөхцөлийг бүрдүүлнэ. Тэгэхээр энэ болбол заавал 100 хувь биш. Гэхдээ бол хуучин бол нөгөө жишээлбэл 10, 20 хувь дээр нь бол дэвшүүлэх юм бол бүртгэлийн шаардлага хангахгүй гэсэн үг. Тэгээд доод тал нь 50 хувь болно. Тэгэхээр ингээд ийм хэмжээтэй нэр дэвшилтийн дэвшихэд болбол нэр дэвшигчдийн тоо их олон болно. Тэгээд хуудасны саналын хуудасны хэмжээ томсоно, саналын хуудсан дээр байгаа тэр тэмдэг тэмдэглэгээ, хүснэгт, үсгийн ирифт энийг бол өөрчлөгдөхгүй. Энэ болбол яг тэр техниктээ тохирогдсон тохиргоотой, униших ийм үзүүлэлт нь яг тогтмол байдаг ийм эд.

Тэгэхээр энийг болбол цаасныхаа хэмжээг томсгоод ар өвөргүй хийхэд болбол бололцоотой гэж үзэж байгаа. Саяны таны яг хэлсэн тийм хэмжээний өгөгдлүүдийг багтаах боломжтой гэж бид нар үзэж байгаа. Тэгээд 12 оны Улсын Их Хурлын сонгуулийн саналын хуудсыг болбол ар өвөргүй хийгээд, тэгээд программчилж байсан ийм туршлага бол манайд байгаа.

**Н.Энхболд:** 4 номер ажлын хэсэг.

**П.Дэлгэрнарэн:** Өдрийн хувьд болбол энийг бол яг Улсын Их Хурал өөрөө тогтоох учраас зүгээр яах вэ бид нар болбол тооцоолохдоо болбол бид нар 26-нд юм болов уу гэж ингэж зүгээр бид нар тэгж байсан, тооцоолж байсан юм.



Гэхдээ одоо тэр гадаадад байгаа иргэдээс санал авахдаа тэр 21, 22 гэдэг хагас бүтэн сайн өдрийг заавал ашиглаж таарч байгаа юм. 28 ч байлаа гэсэн, 26 ч байлаа гэсэн тэр гадаадад байгаа иргэдийн саналыг авахад 21, 22 гэсэн энэ амралтын 2 өдрийг бол ашиглана. Тэгээд урд нь байгаа 5 дахь өдөр, дараа нь байгаа нэг дэх өдөр 2-ыг ингээд оруулаад 4 өдрөө ингэж 7 хоногийнхоо амралтын өдрүүдийгээ дамнуулж ингэж тооцож байгаа.

**Н.Энхболд:** 21, 22 биш ээ, 22, 23 чинь тийм хагас, бүтэн сайн юм байна.

**П.Дэлгэрнаран:** Тийм 21, 22-ны амралтын өдөр.

**Н.Энхболд:** Биш ээ 22, 23 амралтын өдөр.

**П.Дэлгэрнаран:** 22, 23, тэгээд ингээд энэ амралтын өдрөө оруулаад урд талынх нь 2 ажлын өдрийг оруулаад ингэж дамнаж тооцуулъя л гэж хэлж байгаа юм.

**Н.Энхболд:** Хориотой шүү дээ угаасаа оны эхнээс хориотой. Сонгуулийн жилд болохгүй гээд. Үгүй ээ үгүй сонгуулийн жилийн 1 сарын 1-ний өдрөөс эхлээд тэр юмнууд бүгд автоматаар угаасаа зогсож байгаа. Тийм, тийм. Ингэж болно Пүрэвдорж гишүүнээ. Хэрэв та 20, 21, 22, 23 биш 21, 22, 23, 24 гэж байгаа болбол тэрийгээ зарчмын зөрүүтэй саналын томъёолол өгөөд надад өгчих. Энэ манай нам дангаараа шийдээгүй ээ, түрүүн бас Доржханд гишүүн ч ярьсан. Намуудын хувьд бол уг нь энэ асуудал бол бүгдээрээ улс төрийн л өнгөтэй асуудлууд л даа. Тэгээд бүгдээрээ ярьж байгаад л шийдсэн. Тэрийг бас тогтоолын төсөл боловсруулалтаа харгалзаж үзсэн л гэж хэл. Энэ дан ганц манайх шийдээгүй шүү дээ. Зарчмын зөрүүтэй саналуудаа бичээд өгчхөөрэй. Пүрэвдорж гишүүний микрофоныг өгье.

**Б.Пүрэвдорж:** Манай намын дарга бол ийм санал гаргах ямар ч үндэс байхгүй. Энэ намын зөвшилцлөөр явж байгаа гэж би тооцож байгаа. Өөрөөр хэлбэл энэ 3 дахь өдөр санал хураадаг энэ зүйлийг бол олон жилийн туршид ер нь бол маш, сонгуулийн санал хураалтыг өндөр болгохын төлөө л хийж байгаа 1 дүгээрт. 2 дугаарт мэдээж ихэнх ахмад хүмүүс гэртээ байж байгаа. Гэтэл энэ 5 дахь өдөр болчих юм болбол 4 дэх өдрийн орой хагас 5 дахь, хагас сайн, бүтэн сайнд 3 өдөр амрах юм байна гээд л бүх залуу хүмүүс бүгдээрээ амралт зугаалгын газар яваад, бас хөдөө гадаа аав, ээждээ очъё гээд ингээд л явчихна. Тэгэхээр тийм учраас, тийм учраас энэ саналыг бол 28-ны өдрийг манай намын даргад яагаад ч зөвшилцсөн байх ёсгүй гэж үзэж байгаа юм. Энэ бол одоо.../минут дуусав/

**Н.Энхболд:** Одоо яг хэн нь ямар санал өгснийг болбол би хэлж мэдэхгүй нь Пүрэвдорж гишүүнээ. Тэгээд та хэрэв үүнийг наашлуулъя 3 дахь өдөр болгоно гэж байгаа бол бас юугаа өгөөд л яачих саналаа зарчмын зөрүүтэй саналаа бичээд өгчих. Тэгээд л саналаа хураагаад хэдүүлээ явчихъя. Гишүүд асуулт асууж, хариултаа авлаа. Үг хэлэх гишүүн байна уу? Батсуурь гишүүн. Энэ тогтоолтойгоо холбогдуулаад л.

**Ж.Батсуурь:** Тийм энэ нөгөө асуултынхаа цагт асуулт асууж амжихгүй байна л даа. Тийм учраас энэ эрэмбийн асуудал байгаа. Намын эрэмбэ, нэр дэвшигчийн эрэмбийг асуучхаж болно биз дээ одоо? Биш ээ биш, босоо эрэмбэлэх юм уу, хэвтээ эрэмбэлэх юм уу гээд асуугаад байна л даа, тэгэх үү? Тэгэхдээ миний асуултын цаг дээр бол амжаагүй шүү.

**Н.Энхболд:** Энэ одоо энэ дээр хэдүүлээ товоо өдрүүдтэйгээ л тогтоочихъё. Гишүүд үг хэлж дууслаа. Гишүүд үг хэлж дууслаа. Пүрэвдорж гишүүн саналуудаа өгөөрэй. Пүрэвдорж гишүүнээ саналаа, санал хураалгах гээд



байна тийм. Би саналаа хурааж байж болж байна, одоо байгаа саналаараа. Тийм. Саналаа хурааж байя, хүлээж байгаарай, анхаараарай. Тогтоол түрүүн уншаад танилцуулчихсан. 1 дүгээр заалт нь 1 сарын 31-ний өдрөөс эхлээд сонгуулиа зарлаж байгаа, 2 дугаар заалт нь 6 сарын 28-ны өдөр байхаар санал авах өдрийг тогтоож байгаа, 3 дугаар заалт нь 6 сарын 20, 21, 22, 23-ны өдрүүдэд гадаадад амьдарч байгаа иргэдийн саналыг авах өдрийг 4 өдрөөр тогтоогоод, 4 дүгээр заалт энэ тогтоолоо 1 сарын 1-нээс дагаж мөрдөхөөр ийм 4 заалттай тогтоолын төсөл танилцуулсан. Энэ тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Эхний танилцуулсан төслөө. Дараа нь болно. Энэ дэмжигдчихвэл, үгүй ээ ер нь дэгээрээ л явж байна Батсуурь гишүүнээ. Эхлээд оруулж ирсэн төслөөрөө саналаа хураадаг, тэр санал нь унавал зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураагаад явна. Дэмжигдвэл тэр дараагийн зарчмын зөрүүтэй саналаар санал хураахгүй. Тийм. 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж 57,1 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ. Пүрэвдорж гишүүний өдөр өөрчлөх саналуудыг уншъя аваад ир. Тэгэхдээ хураахгүй тийм. Яг дэгээрээ л явж байна гишүүнээ. Тийм.

Пүрэвдорж дарга гишүүн 2 зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. 1 дүгээрт 6 сарын 21, 23, 24 болгохоор гадаадад. 1 дүгээрт санал хураах өдрийг 26-ны өдөр байхаар гэсэн. 2 дугаарт, 3 дахь өдөр тийм 26-ны лхагва гарагт гэж. 2 дугаарт 6 сарын 21, 23, 24-ний өдрүүдэд гадаадад байгаа иргэдээс санал авъя ийм саналын, саналууд гаргасан. Сая тогтоолын төслөө уншаад танилцуулсан. Заалт бүрээр нь уншсан, тогтоолын төсөл дэмжигдсэн. Тэгэхээр одоо таны саналаар санал хураах шаардлагагүй боллоо. Баярлалаа. Баярлалаа 1 дүгээр асуудлаа хэлэлцэж дууслаа. Ээлжилье, санал, дүгнэлтийг, Жаргалмаа гишүүн санал, дүгнэлтийг

бүгдийг нь үү, яах вэ би хамгийн сүүлийнхийг нь л уншчихъя. Тийм. Саяын тогтоолын төслийг чуулганд Жаргалмаа гишүүн танилцуулчихъя. Санал, дүгнэлт тус тусад нь тийм.

17.29 цагт

**Хоёр. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

2 дугаар асуудалдаа оръё. 2 дугаар асуудалдаа оръё. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник, хэрэгсэл хэрэглэх тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Би тогтоолын төслөө уншиж танилцуулъя.

Монгол Улсын Их Хурлын тогтоол. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник хэрэгсэл хэрэглэх тухай. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1. Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн сонгогчдын бүртгэлийн үйл ажиллагаанд бүртгэлийн техник, хэрэгслийг санал авах тоолох дүн гаргах үйл ажиллагаанд new image cast санал тоолох төхөөрөмжийг хэрэглэхийг зөвшөөрсүгэй. Энэ тогтоолыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө гэсэн ийм тогтоолын төсөл байна. Энэ болбол Техник, автоматжуулсан системийн тухай хууль гараад тэрнээс хойш явсан бүх сонгууль дээр гарч байсан ийм тогтоол байгаа юм. Асуулт байна уу? Пүрэвдорж гишүүн. Батсуурь гишүүн, Пүрэвдорж гишүүн, Доржханд гишүүн 3 гишүүнээр тасаллаа. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Энэ сонгуулийн автоматжуулсан системийн тухай тогтоол батлах гэж байна. Тэгээд энэ дээр юутайгаа яаж уялдах вэ? Бүх тойргийг гар тооллогоор тоолохоор заачихсан гэж ойлгож байгаа. 100 хувь тоолох зөв үү 1 дүгээрт? 2-т гэвэл хэрвээ зөрвөл гар тооллогын дүнг үндэс болгоно гэсэн заалт байгаа гэж би бодож байгаа.

**Н.Энхболд:** Байхгүй, байхгүй.

**Ж.Батсуурь:** Тэгвэл тоолохын хэрэг юу байгаа юм бэ?

**Н.Энхболд:** Хянаж байгаа, та юу яачих тийм.

**Ж.Батсуурь:** Тэгээд юу түрүүнд би асууж байгаад орхичихсон. Босоо дараалалтай байх юм уу, хэвтээ дараалалтай байх юм уу? 1 дүгээрт нам бүртгэлээрээ улсын бүртгэлийн дарааллаар байх юм уу, ээлжилж солбих юм уу, сугалах юм уу? Ардын нам нь л нэгдээ байдгаараа байх юм уу гэсэн ийм зүйл байгаа.

2-т гэвэл босоо нь ингээд цуваа хэлбэртэй байх юм уу, хэвтээ хэлбэртэй байх юм уу? Эрэмбийг асуучихлаа. Эрэмбийг нам дотроо шийднэ гэж байна. 2 эрэмбэ гарч ирнэ. Жагсаалтын эрэмбэ, тойргийн эрэмбэ, хоёуланг нь нам дотроо шийднэ гэсэн үг үү? Яана гэсэн үг вэ? Сонгуулийн хороо энэ дээр ямар хяналт тавих вэ гэж? Энэ Нью имидж каст санал тооллогын төхөөрөмжийг хэрэглэхийг зөвшөөрсүгэй гэж. Энэний ерөнхий хяналт нь хаана байх юм бэ? Гараад ирснийг нь бол гар тооллогоор хянах юм байна. Энэний ерөнхий төхөөрөмжийн аудит, хяналтыг хаана хийлгэх юм бэ? Хэрвээ Монгол Улсын хэмжээнд сонгууль будилаантаад гэдэг юм уу, энэ системийн доголдоос болоод гэдэг юм уу, гацсанаас эвдэрснээс болоод дахин нөхөн янз бүрийн сонгууль явахад энэний гарах үр дагаврыг хаана хянаж, аудит хийж байгаа вэ? Энэ хаанахын программ дээр хийгдэж байгаа вэ?

Үүнтэй үргэлжлүүлээд ийм зүйл гарч ирж байгаа. Өмнө нь яригдаж байхад яг улсын нэгдсэн бүртгэл гэж байхгүй гэдгийг бол хэлээд байгаа шүү дээ. Жишээлбэл Хаан банкны гүйлгээ шиг хаа нэгтээ газар 5 мянган төгрөгийн гүйлгээ хийхэд үлдэгдэл нь бүгд мэдэгдэхгүй. Яагаад вэ гэхээр Алтайн цаадах говьд гэдэг юм уу бусад газраас ишлэн кабель холбогдоогүй гэдэг юм уу энэ газраас ирсэн зүйлийг тойрог дээр нь шивдэг гэж ингэж хэлж байгаа юм л даа. Тэгэхээр тэр асуудал энэ дээр яаж шийдэгдэж байгаа вэ гэж?

**Н.Энхболд:** Дэлгэрнарэн дарга хариулъя. Гар тооллогын дүн, хяналтын тооллогын тухай.

**П.Дэлгэрнарэн:** Хяналтын тооллого, тооллогын талаар Батсуурь гишүүний асуусан асуултад хариулъя. Хяналтын тооллого болбол 100 хувь хийгдэнэ. Энийг 21 оны Ерөнхийлөгчийн сонгуулиас хойш бүүр тухайн сонгуулийнхаа хуульд заагаад тэр нөгөө сонголтоор хийдэг байсан хяналтын тооллогыг 100 хувь болгож байгаа. Ер нь бол бид болбол төхөөрөмжийн тоо, хяналтын тооллогын тоо болбол зөрөхгүй байх ёстой гэж үзэж байгаа. Тэгээд яг хуульдаа болбол юугаараа тоолоод, 2 тоогоо нийлүүлж тоолоод шалгахад зөрж байсан тохиолдол бол урьд нь бол байхгүй. Тэгэхээр болбол хяналтын тооллого юу төхөөрөмжийн тооллогынхоо дүнг дэлгэцээр шууд дамжуулж үзүүлээд, тэгээд араас нь тухайн хэсэг тойрог дээр гар тооллогыг хяналтын тооллогыг 100 хувь бүгдийг нь хийж нэгтгэж шалгаж үзнэ гэсэн үг.

Дараа нь таны асуусан асуулт дээр энэ эрэмбийг яаж тогтоох юм бэ гэж. Намууд болбол Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаараа бичигдэх байх тийм. Тэгэхдээ төхөөрөмж болбол түүн дээр уншдаг. Тэр хэвтээ байх уу, босоо байх уу гэдэг дээр бол ерөөсөө 2 багана байх уу, 3 багана байх уу гэдэг л асуудал

байгаа. Тэр бол төхөөрөмжийн яг өөрийнх нь уншдаг ийм юу гэх юм бэ дээ формат гэх юм уу тийм юм байгаа юм. Тэгэхээр 3 багана болгох уу, 2 багана болгох уу л гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр саналын хуудсыг болбол хууль дээр СЕХ батална гэж байгаа. Тэгэхээр одоо бид нар болбол сая нөгөө яриад байсан судалж байна гээд байсан нь тэр, тэгээд бид нар болбол нөгөө хуулийн хугацаанд нь саналынхаа хуудсыг хийгээд, СЕХ-гоор хэлэлцэж батална гэсэн үг.

**Н.Энхболд:** Ер нь техникийн ерөнхий хяналт, хаанаас авсан машин, программ хэн хийж байгаа юм, тэрийг яаж хянадаг юм?

**П.Дэлгэрнарэн:** Энийг манай Банзрагчдорж, манай Мэдээлэл, технологийн төвийн ахлах референт Банзрагчдорж.

**Н.Энхболд:** 3 номерын микрофон.

**А.Банзрагчдорж:** Санал тоолох төхөөрөмжийн хувьд бол АНУ-аас худалдаж авсан ийм санал тоолох төхөөрөмжүүд байгаа. Ер нь 2012 оноос хойш ашиглаад ирсэн. Программ хангамжийн хувьд манайх өөрсдөө 100 хувь хариуцаад хийдэг. Тэгээд хяналтыг нь манай СЕХ өөр дээрээ хийдэг байгаа. Тийм мөн, мөн. Тэгээд энэ программ хангамжийг хянах юуг нь асууж байх шиг байсан түрүүн. Хяналтыг нь болохоор ажлын хэсэг байгуулагдаж хяналтыг нь хийдэг. Тэр ажлын хэсэгт нь тагнуул, цагдаагийн байгууллагуудаас хүмүүс оролцоод, ажлын хэсэг болоод, тэгээд.

**Н.Энхболд:** Ер нь болбол энэ тоног төхөөрөмжүүд тусгай хамгаалалтад байдаг. Тэгээд сонгуулийн өмнө, дараа нь сая хэлсэн Банзрагчдоржийн хэлснээр тагнуул, цагдаа, мэргэжлийн байгууллагууд оролцож байгаад хяналт тавьж үздэг, шалгадаг, ялангуяа сонгуулийн өмнө болбол туршилт хийж үзэж гадна,

дотнын нөлөө байна уу гэдгийг нь шалгаж баталгаажуулдаг ийм журамтай байгаа.

Нам доторх эрэмбийн хувьд бол хуульд заачихсан шүү дээ. Энийг бол намууд өөрснөө л дотроо асуудлаараа шийднэ. Танай намын л өөрсдийн л асуудал шүү дээ. Хуулиар болбол тийм Дээд шүүхэд, хэлчих намуудыг сүлжиж болох уу, сөөлжүүлж болох уу? Тэр намуудын доторх асуудал даа уг нь. Тийм. Тийм машин нь төвөгтэй, тэр нь өөрөө нөгөө программд нь таардаггүй юм байна лээ тийм, зөв үү миний хариулт. Үгүй. Тэгээгүй тийм. Харин энэ хэний Батсуурь гишүүний асуулт дунд нэг ийм үг гарчихлаа. Нэгдсэн бүртгэл гэж юм байхгүй гээд. Түүн дээр та нар хариулт өгөөдөх. Хуучин энэ чинь иргэний бүртгэлийн жагсаалтаар явдаг байсан. Одоо сонгогчдын бүртгэл гэж тусдаа гардаг болсон, хянадаг болсон тийм ээ. Энэ юмнуудаа тайлбарлаад хэлээдэх. Энэ чинь олон нийтэд бас мэдээлэл хэрэгтэй. Тийм. Нэг л, санал авдаг нэг л юу байгаа. Бүртгэл байгаа. Тийм. Дэлгэрнарэн.

**П.Дэлгэрнарэн:** Бат-Эрдэнэ дээр.

**Н.Энхболд:** Бат-Эрдэнэ 1 номер.

**Д.Бат-Эрдэнэ:** Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд зааснаар сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх ажиллагааг бол улсын бүртгэлийн байгууллага бие даан хариуцаж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаж байгаа. Улсын Их Хурлын Сонгуулийн хуульд зааснаар болбол сонгогчдын нэрийн нэг л жагсаалт гардаг. Энэ жагсаалтыг үйлдэх үндсэн бааз нь болбол сонгогчийн биеийн давхцалгүй өгөгдөл дээр үндэслэсэн энэ бааз дээр үндэслээд нэрийн жагсаалтыг үйлддэг. Энэ удаагийн хуульд оруулсан нэг онцлог өөрчлөлт маань бол ямар нэгэн давхцал байна уу, үгүй юү гэдгийг хөндлөнгөөс шалгах бололцоог маш олон талаар оруулж өгсөн. Улс төрийн нам эвсэл

өөрсдөө шалгана. Мөн сонгуулийн үйл ажиллагаанд хяналт тавьж, оролцож байгаа иргэд, төрийн бус байгууллагууд бас хяналт тавих энэ боломжийг хуулиар олгож бүрдүүлсэн байгаа.

**Н.Энхболд:** Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Нөгөө асуулт, хариулт 2 юу яагаад байна зөрөөд байна. Ингэж байгаа юм. Өмнө нь Байнгын хороон дээрээ ярьж байхад иргэний бүртгэлийн нэгдсэн систем байдгийг бол ойлгож байгаа. Маши сайн ойлгож байгаа. Сонгогчийн нэрсийн жагсаалт гарч байгаа. Ингэдэг шүү дээ. Гэнэт төдөд явж байснаа төдөн санал гэнэт ороод ирсэн, тэр луйвар байсан, луйваргүй байсан гээд маргадаг. Тэгэнгүүт ямар тайлбар болдог вэ гэнгүүт тэр чинь сүлжээнд байхгүй шилэн кабельгүй газар байсан юу, тойргийн систем дээрээс нэгтгэгдээд ирснийг бид нар шивсэн юм гэж байгаа байхгүй юу. Тэгээд ингээд бөөн ороод ирдэг тийм ээ, энэ асуудал бол яаж байна вэ гэхээр жишээлбэл Хаан банк ямар нэгэн банкны гүйлгээ бол дансанд нь сая төгрөг байлаа гэж бодоход 100 мянган төгрөгийн гүйлгээ хийхэд шууд 900 мянга болдог. Шууд тийм ээ. Гэтэл сонгогчдын энийг бол нэгдсэн бүртгэл хийж байгаа юм, нэгдсэн систем, тийм үү, нэгдсэн систем. Гэтэл Алтайн цаадах говь байдаг юм уу.../минут дуусав/

**Н.Энхболд:** Минут дахиад нэг минут өгчих. Та товчхон шиг асуучих. Тийм.

**Ж.Батсуурь:** Харин тэрийгээ би тодруулж яаж байна л даа. Улсын бүртгэлээ авчрахгүй яасан юм бэ тэгвэл? Тэгье тэгвэл. Ер нь бол тэрийг яах вэ л гэж асуугаад байгаа юм. Бид нарын л хамтын л ажил шүү дээ. Тэгэхээр хүмүүст мэдээлэл өгөх гээд асуугаад байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо Улсын бүртгэл нь Сонгуулийнхаа ерөнхий хороо руу, СЕХ нь Улсын бүртгэл рүүгээ, Улсын бүртгэл нь хаашаага ч байдаг юм

хийдэг биш, бид нарын бүх ажлын систем нэгдсэн ойлголттой, ард иргэд нь сонгох хүн нь, сонгуулах хүн нь бүгдээрээ ижил ойлголттой байж л маргаангүй сонгууль болно биз дээ. Энэ талаас нь асуугаад байгаа байхгүй юу.

**Н.Энхболд:** Дэлгэрнараран дарга 4 дүгээр микрофон өгчхөөрэй.

**П.Дэлгэрнараран:** Батсуурь гишүүний асуултад хариулъя. Яг гишүүнтэй бид бол санал нэг байгаа. Яагаад гэвэл нэгдсэн жагсаалтыг одоо бол нөгөө тойрог, хэсгүүдийн хороод нь хуваарилаад, хургуулээд байгаа, нэрсийн жагсаалтуудыг. Тэгэхээр энэ болбол ийм онлайн хэлбэрт байх ёстой юм гэж та болбол бас хэлээд байгаа. Бид нар ч бас яг тэгж хэлээд байгаа юм. Яг ийм онлайн хэлбэрт хаана ч явж байгаад санал өгсөн хүн тэр хүний санал өгсөн бүртгэл унадаг, тэгээд буцаж сэргээггүй, тэгээд яг ингээд давхцахгүй байх ийм нөхцөлийг бүрдүүлж танилцуулаач гэдэг хүсэлтийг бид нар Улсын бүртгэлийн газарт байнга тавьж байгаа. Хэрэв та нар тийм боломжгүй юм бол яг одоогийн байдлаар та нар нэгдсэн жагсаалтаа гаргаад, тойрог хэсгийн хороодод ингээд хуваарилаад явж байгаа юм чинь хоорондоо ямар ч зөрөөгүй байх нөхцөлийг бүрдүүлж, тайлбарлаж өгөөч л гэдэг ийм л хүсэлтийг бид нар тавиад ажиллаж байгаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Пүрэвдорж гишүүн асууя.

**Б.Пүрэвдорж:** Өнгөрсөн хавар Монголын ард түмэн огт хүсээгүй байж байхад, ихэнх нь хүсээгүй байж байхад Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт явагдсан. Тэрний үр дүнд 126 гишүүнтэй болсон, пропорциональ систем орж ирсэн байгаа. Тэгээд би ард түмний талд байсан. Тэгэхдээ хамгийн эцэс дээр нэгэнт л ард иргэд энэ Их Хурлын гишүүд 126-гаа дэмжихээр шийдчихсэн тохиолдолд бол хамгийн сүүлийн шаардлага болгож Их Хурлын дарга,



Ерөнхий сайд нарыг энэ яг энэ танхимд Байнгын хороо тэр 126 болох асуудлыг шийдвэрлэж байхад оруулж ирэхийг шаардсан. Миний шаардлага бол 108 гишүүнтэй больё гэдэг ийм шаардлага байсан. Тэгээд энэ дээр бас тодорхой буулт хийхдээ нэг зүйлийг бас шаардсан байгаа. Энэ бол энэ СЕХ сүүлийн сонгуулийг бол ямар ч программгүйгээр энэ сонгуулийг явуулсан. Тийм учраас энэ СЕХ-ны энэ санал тооллогын машин болон программ хангамжид зориулж 53 тэрбум төгрөг тавихыг шаардсан байгаа юм. Тэрний үр дүнд улсын төсвийн тодотголоор Их Хурлын дарга болон Ерөнхий сайд нар энэ төсвийн тодотголоор энэ асуудлыг чинь оруулж шийдвэрлэнэ гээд тэрний дагуу 15,9 тэрбум төгрөгийг энэ СЕХ-н дээр *dominion voting* санал тоолох машин болон программ хангамж мөн түүнчлэн 18 тэрбум төгрөгийг Улсын бүртгэлийн газрын хурууны хээний тоног төхөөрөмжийг шинээр худалдаж авах программ хангамжтай нь худалдаж авах тэр хөрөнгийг шийдсэн байгаа.

Тэгээд энэний үр дүнд өнөөдөр энэ Нью имиж Каст гээд энэ юу програм хангамжаа оруулж ирж байна гэдэг чинь бол энэ төсвийн тодотголоор хийгдсэн хөрөнгө оруулалтын хүрээнд хийгдсэн л гэж би үзэж байгаа. Тэр би бол ийм маш их тийм итгэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл энэ 12 онд сонгуульд ялагдаж байхдаа ч би энэ юунд итгэж байсан сонгуулийн санал тоолох машинд. Ялж байхдаа ч 16 онд итгэж байсан яг хэвээрээ байгаа. Өөрөөр хэлбэл энэ хооронд хэн нэгэн миний ах, дүү нар тэр энэ тэр санал хураалтын машин чинь ийм асуудалтай байна шүү гэж нэг ч хэлээгүй. Надад итгэдэг маш их олон намын маань нөхдүүд энд тэнд ажлын хэсэгт юу сонгуулийн ажлын хэсэгт орж ажиллаж байгаа, тэд нар ч гэсэн бас янз янзын юм ярьж байгаагүй. Тийм учраас ялагдсан хүмүүсийн яриа л юм гэж би ойлгодог. Тийм учраас энэ ард иргэдэд итгэлтэй байлгах энэ гол зүйл чинь бол энэ санал хураалтын л машин болон түүний

программын асуудал байгаа. Тэгээд энэ дээр дахиад 100 хувь тоолно гэдэг чинь бас дахиад зөв. Ерөнхийлөгчийн сонгуулиар ч гэсэн бас асуудал гараагүй. Тэгэхээр энэ дахиад ямар энэ ирэх оны төсөв дээр бас тодорхой хөрөнгийг бас дахиад тавьсан байна лээ. Тэгээд энэ дээр ямар, ямар ажлууд хийгдэх юм бэ? Энэ санал тоолох төхөөрөмжүүд чинь ер нь бол ард иргэдэд баталгаатай энэ асуудал байхгүй юм гэсэн тийм итгэл үнэмшил төрүүлэхүйц та нарт ямар тийм тайлбар байна гэдгийг асууя.

**Н.Энхболд:** Хэн 4 номер Дэлгэрнаран дарга хариулъя. Нэмж үг авч хэлье.

**П.Дэлгэрнаран:** Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Юуны өмнө Пүрэвдорж гишүүнд бас СЕХ-ныхоо нэрийн өмнөөс талархал дэвшүүлъя. Яагаад гэвэл манай бас асуудлыг ойлгож, өнгөрсөн жил бид нарын сонгуулийн Сонгогчдын нэрсийн жагсаалт, бүртгэл хяналтын дэд хорооны хурал дээр танилцуулсан танилцуулгыг үндэслэж, санал гаргаж, төсвийн тодотголоор тодорхой хэмжээний эх үүсвэр шийдэж, ингээд бид нарын худалдаж зайлигүй худалдаж авах шаардлагатай тоног төхөөрөмжүүд түүнийг дагалдах хэрэгслүүдийг худалдан авах боломжийг бүрдүүлэхэд дэмжлэг бас үзүүлсэн гэж бид нар бол бодож талархаж байна. Тэгээд бид нар өнгөрсөн 23 оны өнгөрсөн биш, одоо 23 оны төсвийн тодотгол дээр бид нарт 15,9 тэрбум төгрөгийн эх үүсвэр тавьж өгсөн. Бид нар болбол яг одоогийн байдлаар болбол 3 мянган төхөөрөмжтэй болж, нөхөн бүрдүүлэлт хийж, байхаар тооцож нөхөн бүрдүүлэлт хийж чадлаа. Тэгээд холбогдох бүх дагалдах хэрэгслүүдийг бүгдийг нь худалдаж авч, яг одоогийн байдлаар бол бид нар өөрийнхөө саванд оруулж авсан. Тэгээд одоо болбол тохируулга шалгалтын ажлуудыг болбол хийж байна. Төлбөр тооцооны асуудлууд болбол яг ид хийгдээд ингээд явж байна.



Тэгэхээр болбол 24 оны сонгууль дээр болбол сонгогчдын тоо болбол нэмэгдэнэ. Яг одоогийн байдлаар болбол мөн 200-гаад мянган сонгогчид бол урд ээлжит сонгуулиасаа нэмэгдчихсэн явж байгаа. Тэгээд энийг дагаад хэсгийн хороод нэмэгдэнэ. Хэсгийн хороод нэмэгдэнэ гэдэг болбол төхөөрөмжийн тоог нэмэх шаардлагатай гэсэн үг. Тэгэхээр бид нар болбол энэ тооцооллуудаар үзэхэд болбол бид нарын техник, тоног төхөөрөмжийн тоо хүртээмж болбол хангалттай гэж бэлтгэгдсэн гэж хэлэх байна. Тэгээд программ хангамжтай холбоотой асуудал дээр болбол урьд нь явж байсан программ хангамжуудаа бол бид нар яг хуулийн хугацаанд нь, гэрээний хугацаанд лицензийн төлбөрөө төлөөд ямар ч асуудалгүй явж ирсэн. Программ хангамжийн хувьд болбол цаашдаа ч бас асуудалгүй явна. Сая манай мэргэжлийн хүмүүс хариулсан. Программыг болбол бид дангаараа манайх программ хангамжийнхаа асуудлыг шийдвэрлээд ингээд найдвартай явах боломж бол бүрэн бүрдсэн байгаа. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа.  
Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Яг энэ асуудлыг хэлэлцэж байх үед энэ ТББХ-ны дарга Энхболд дарга маань бас энэ талаар маш их дэмжлэг үзүүлж, шахалт үзүүлж бас энэ асуудлыг шийдсэн танд бас талархлаа илэрхийлье. Тэгээд гол асуудал байна. Өөрөөр хэлбэл нэг тийм олон нийтэд танилцуулж байх үед нэг таслал гарчхаад, таслалаас болоод бид нар баларчихлаа л гэдэг ийм юм яриа гараад байгаа юм. Тэгэхээр *dominion vote* одоо энэ санал асуулгын тоног төхөөрөмжөөс нөгөө олон нийтэд танилцуулахад тэр саналыгаа нэмж байгаа тэр зүйлийгээ автоматжуулах, хүний хамааралгүй болгох, өөрөөр хэлбэл та нар чинь нэг *excel* дээр хийгээд л, тэгээд тэрийгээ л гаргаад байсан юм шиг байгаа юм. Тэгээд түүн дээр чинь хүмүүс маш их асуудал

байна гэж гомдоллоод одоо хүртэл яваад байгаа юм. Энэ асуудлыг яаж шийдвэрлэж байгаа вэ?

**Н.Энхболд:** 3 номер.

**А.Банзрагчдорж:** Саяын тэр таслалын асуудал болохоор яг үндсэн санал тоолох саналаа нэгтгэдэг программ хангамжаас арай өөр, одоо дэлгэц рүү иргэдэд харуулахад шууд дамжуулалтаар харуулахад арай эвтэйхэн байдлаар харуулах үүднээс өөр программ хангамж ашигласан байгаа. Тэрэн дээр л зөвөөрлөхөд нэг жоохон форматын алдаа гараад тийм таслалтай харагдсан. Одоо үндсэн системд бол тэр нь ямар ч хамаагүй байгаа. Тэгээд одоо энийг бол арай өөр загвараар бүүр эвтэйхнээр харуулахаар, хүний ажиллагааг оролцуулахааргүй тийм автоматаар хийхээр ажиллаж байгаа.

**Н.Энхболд:** Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Урьд нь болбол жишээ нь Ховд аймагт яг тэр манай төлөөлөгч нар, яг ажиглагч нар тэр бүх хүмүүс бүгдээрээ бид нар луу тоогоо өгөөд, бид нар бол жишээ нь яг би миний санал хэд байна вэ гэдгийг бүгдийг нь тоолоод гаргачхаж байгаа юм. Гэтэл бусад аймгууд би мэдэхгүй тэнд би хүмүүсээ ажиллуулж чадахгүй, надад тийм нөөц бололцоо байхгүй. Тэгээд ямар асуудлууд гарсан бэ гэхээр том, том аймгууд дээр том, том хотын тойргууд дээр энэ таслалын чинь асуудал гараад ирсэн байхгүй юу даа. Би бол жишээ нь Говь-Алтайн Бугат сумаас би шууд тэр дороо мэдээлэл авах хүн надад байхгүй байхгүй юу. Тийм учраас энэ хөдөө орон нутгийн хяналт чинь маш сайн явсан байхгүй юу. Хариуцлагатай хүмүүс. Сонгуульд ялагдах нь хаячихсан байж магадгүй л дээ. Тийм учраас энийг энийг би энд яаж би итгэх юм бэ? Энэ жишээ нь улс орон даяар гарчхаад Пүрэвдорж уначихсан гэх юм бол тэгээд би хэчнээн яваад ч нэмэр байхгүй шүү дээ. Тийм

учраас энэ нөгөө олон нийтэд танилцуулж байгаа тэр зүйлээрээ нэгэнт л тийм.../минут дуусав/

**Н.Энхболд:** Нэмэх үү Банзрагчдоржоо, 3 номер.

**А.Банзрагчдорж:** Энэ санал авах байр болгоноос хэсгийн хороо болгоноос дүн нь ирж байгаа. Энэ дүн ирээд сервер дээр нэгтгэгдэж байгаа. Сервер дээр ирж байгаа дүн болохоор манай веб сайт дээр ороод явдаг. Энэ веб сайт дээр ордог дүнгээс гадна бид нар сервер дээр ирдэг дүнгээ дэлгэцээр шууд дамжуулж харуулахдаа эвтэйхэн хувилбараар харуулах гээд түүн дээр л нэг тийм асуудал гарсан байгаа. Тэгэхээс биш сервер дээр ирж байгаа дүн бол нэгтгэгдээд яг зөв ирдгээрээ бол ирж байгаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Доржханд гишүүн асууя.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр энэ техник, хэрэгслийг шинэчлэх, шинээр санал тоолох машин хэрэглэхийг бол дэмжиж байгаа. Тэгээд бүүр тэрнээс илүү асуулт нь юу байна гэхээр одоо ингээд сонгууль чинь энүүгээр л явж байгаа шүү дээ гар утсаар. Тэгээд одоо пропорциональ элемент ингээд орчихсон. Гадаадад байдаг Монголчууд бүгдээрээ ингээд гар утсаараа санал өгөх бүрэн боломжтой. Хөдөө орон нутагт байгаа Монголчууд бас бүгдээрээ л боломжтой. Ингээд тойргийн хуваарилалтад ингээд орохоор ингээд яригдаж байна. Бүсчилсэн байдлаар. Тэгэхээр энэ агуулгаараа бол нөгөө сонгуулийн тэр цэг дээрээ хүрч ирээд саналаа өгөх эсэх нь бол байдаг юм байгаа биз. Нөгөө талдаа бол ядаж энэ нөгөө гар утсаараа өгчихдөг тэр боломжийг нь нөгөө нээгээд өгчихмөөр байгаа л даа. Нэлээн олон улсууд бол ашиглаад эхэлчихсэн.

Түрүүчийн яриад байгаа 4 дэх өдөр байх юм уу, 3 дахь өдөр байх юм уу, 5 дахь өдөр байх юм уу, залуучуудын

оролцоо нь ямар байх юм бэ гэдэг, гадаадад байдаг тэр олон хотуудаас нисэж ирээд өндөр 5, 600 мянган доллароо төлөөд нисэж ирээд саналаа өгсөн жишээнүүд аягүй олон байгаа байхгүй юу хөөрхий. Энэ бүх тэр зардлуудыг чинь ингээд хэмнэх энэ Монгол Улсын ардчиллыг ингээд бэхжүүлэх, сонгуульдаа оролцдог тэр оролцоог нь идэвхийг нь нэмэгдүүлэх боломж нь ерөөсөө энэ шүү дээ. Одоо хүн болгон л ингээд Хаан банкны карттай биз дээ, дансаар. Тэгээд гүйлгээ хийхдээ нууц кодоо хийгээд л ордог биз дээ. Хур мэдээллийн систем нь, тэгээд хуруугаа уншуулаад ингээд орж болно. E-signature гэж бас байна. Баталгаажуулах бүрэн боломжууд нь байгаа л байхгүй юу. Тэгэхээр яг энэ чиглэлээр ингээд хийгдэж байгаа ажил байна уу, боломж байна уу? 2024 оны 6 сар гэхэд нэг.

2-т нь энэ зарим аймгууд чинь ингээд магадгүй 10 хүртэл мандаттай болчихоод байна шүү дээ. Тэгэхээр ингээд асуудал үүсээд байна л даа. Нөгөө дутуу бөглөчихвөл яах юм бэ? Хүчингүйд тооцох юм уу саналын хуудсыг, илүү бөглөчихвөл яах юм хүчингүйд тооцох юм уу? Өмнөх сонгуулиар чинь бүүр ингээд буруу мэдээлэлтэй хүмүүс их байна шүү дээ, байсан байна лээ шүү дээ. Та зөвхөн нэг л намыг дугуйлна шүү үгүй бол хүчингүй шүү гээд л ингээд иргэд мэдээлэл байхгүй. СЕХ мэдээлэл өгдөггүй. Өнөөдөр би ингээд бүх сумдаар явж байна. Ямар дүрмээр яаж явах юм энийг мэдэж байгаа хүн нэг ч алга. Тэгээд энэ тохиолдолд нөгөө мэдээллийг нь өгөх ийм шаардлагатай байна. Тэгээд нөгөө талдаа энэ машиныг оруулж ирснээрээ хэрвээ дутуу бөглөчихсөн байх юм бол буцаж гаргаад та дутуу байна, илүү бөглөчихсөн бол илүү байна гээд буцаж гаргаж өгөөд, тэгээд бүрэн гүйцэт бөглүүлэх тэр боломж нь байгаа юу? 2 дахь асуулт. Энэ аягүй чухал байна шүү тийм биз?

3 дахь нь юу байна гээд тэгэхээр нөгөө яах вэ нөгөө намуудыг бол үндсэн

Дээд шүүхийн бүртгэлээр нь ингээд жагсаана гээд. Тэгээд энэ чинь бол олон улсад байдаггүй. Манайхан чинь хөөрхий нэг олон урьд шөнө нь очиж Дээд шүүхэд ингээд бүртгүүлчихсэн 1, 2, 3 гэгчихсэн болохоор тэрийгээ л ингээд хадгалах гээд байх шиг байна л даа. Гэтэл олон улсад энэ чинь саналын хуудас дээр дарааллыг тогтоохдоо сугалаагаар явуулдаг аль эсвэл ядаж нөгөө өмнөх сонгуулийнхаа үр дүнгээр ингэж жагсаадаг энэ чинь парламентын ардчилал шүү дээ. Тэгээд ийм шинэчлэлээсээ бас жаахан ухарчих гээд байна л даа. Одоо асуулт нь юу байна вэ гээд тэгэхээр эвсэл байгуулагдаад, намуудын араас эвслүүд нь ингээд гарч ирэх юм уу, аль эсвэл нөгөө эвсэлд орсон намын дээд шүүхийн бүртгэлээр та нар жагсаах гээд байна уу? Тэгэх юм бол нөгөө 3, 4, 5-д байгаа намууд чинь тэгээд л үнэд ороод л ингээд л нэг хөгийн систем рүүгээ яваад л орчихно шүү дээ. Тэгээд л дахиад л ингээд л нэг заварсан мөнгөний сонгууль руу орчих ийм магадлал байна. Энэ дээр бас хариулт авъя. Баярлалаа.

**Н.Энхболд:** Дэлгэрнаран дарга 4 номер.

**П.Дэлгэрнаран:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Ер нь бид нар болбол сонгогчдод цахимаар сонгууль өгөх боломжийг өгөхийн төлөө ажиллаж байгаа. Энэ дээр бол бид нар судалгааны ажил хийгдэж байгаа. Зарим чиглэлээр болбол хүмүүсээ яваад явуулаад сургасан, тэгээд одоо бас энэ жишиг болж байгаа Эстони улс дээр улсын сонгуулийн цахим сонгуулийн системийг хийсэн хүмүүс, компанитай одоо бид бас ярьж байна. Европын Холбооноос бид нар бас зөвлөмж авч ажиллаж байгаа. Тэгэхээр энэ бол дараагийн сонгуульд бол бид нар болбол сонгогчдод цахимаар сонгуулиа өгөх ийм боломжийг болбол өгөх ёстой гэж үзэж, зорилт тавьж ажиллаж байгаа. Одоо сонгууль зохион байгуулалт болон байгуулалттай холбоотой асуудлуудыг болбол цахимжуулж хөнгөвчлөх

асуудлаар бид нар e-election гэдэг системийг бид нар хөгжүүлж байгаа. Тэгэхээр энэ дээр бол манай сонгуульд жишээлбэл 10 гаруй, 20-иод мянган төрийн албан хаагчид, бас 10-аад мянган хамгаалалт цагдаа хүчний байгууллагын ажилтнууд, тэгээд ажиглагчид, улс төрийн намын ажиглагчид гээд маш олон хүнийг хамарсан улсын хэмжээний ийм ажил болдог учраас энэ ажлуудаа болбол хуучных шиг ийм хүндрэлтэй хэлбэрээр биш бүгдийг нь цахим хэлбэрээр явуулах, мөн бие даагч нэр дэвшигчид болбол 801 хүний гарын үсгээ цуглуулдаг байгаа. Тэгэхээр энийг шалгах, бүртгэхтэй холбоотой бүх үйлдлүүдийг цахимжуулах, мөн ирцтэй холбоотой асуудлыг цахимжуулах гээд ингээд ийм систем бол хөгжүүлээд бид нар бол дууссан. Одоо болбол ашиглахад бэлэн болж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Бат-Эрдэнэ нэмэх үү? 1 номер, 1 номерын микрофон өгөөрэй.

**Д.Бат-Эрдэнэ:** Доржханд гишүүний асуултад хариулъя. 2 дахь асуулт буюу Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд зааснаар тойрогт ноогдох мандатын тооноос илүү эсвэл дутуу санал тэмдэглэх юм бол тухайн саналын хуудсыг хүчингүйд тооцно. Гэхдээ тухайн сонгогчид болбол дахиж нэг удаа зөв дугуйлах саналын хуудсыг нэг удаа өгнө. Мэдээж СЕХ-ны хувьд болбол энэ тойрог хэрвээ томсож байгаа болбол олон нэр дэвшигч бүртгэгдэнэ гэж тооцож байгаа бол энэ саналын хуудсан дээр яаж саналаа тэмдэглэх вэ гэдэг энэ заавар зааварчилгааг болбол маш сайн өгөх нь чухал. Энэ чиглэлд СЕХ бас илүү сайн анхаарч, зөвхөн СЕХ ч биш, ОУБ, төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллана гэж бол төлөвлөж байна.

3 дугаар асуултын тухайд Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хэлэлцэх үеэр ч бас яригдаж л байсан асуудал. Одоо яг хүчин

төгөлдөр мөрдөгдөж байгаа хуулиар болбол намын нэрийг Улсын Дээд шүүхэд бүртгүүлсэн дарааллаар хэрвээ эвсэл болж орох юм болбол эвсэлд байгаа намуудаас хэн нь хамгийн түрүүнд Улсын дээд шүүхэд бүртгүүлсэн байна гэдэг тэр дарааллын харгалзаж саналын хуудас дээрээ бичнэ гэсэн ийм хуульчилсан зохицуулалтаар бол явна. Энэ Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 60 дугаар зүйл дээр бол илүү тодорхой биччихсэн байгаа юм байна.

**Н.Энхболд:** Доржханд гишүүн тодруулж асууя.

**Т.Доржханд:** Тэгэхээр нөгөө цахим энэ бэлтгэл ажил маань ингээд хийгдэж байна. Тэгээд энэ маань ингээд 2024 оны сонгуулиар энийгээ ингээд ашиглаад явах боломжтой гэж би ойлголоо зөв үү нэг? 2 дугаарт болохоороо Бат-Эрдэнэ даргын хариулт болохоороо хэрвээ илүү юм уу, дутуу тохиолдолд нэг удаа засах боломжтой байна гэж хэлж байна. Тийм ээ. Тэгээд бид нар бол энэ мэдээллүүдээ өгөөд явна гээд. Энэ дээр чинь бол бид ингээд хамтраад явахад бэлэн шүү. Та нар Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн яг л энэ өгөөжийг өгөхийн тулд бид нар сонгуулиа зөв явуулахгүй бол болохгүй болчихоод байгаа тийм биз? Тэгэхээр тэр төсвийн хөрөнгийг нь нэмээд олон улсын байгууллагуудын хөрөнгө гээд энэ дээр бол хангалттай хаях ёстой юм. Миний нөгөө харин тодруулах гээд байгаа асуудал нь хэрвээ ингээд дутуу юм уу, илүү байсан тохиолдолд машин уншаад гаргаж ирээд наадах чинь дутуу байна, илүү байна гээд гаргаж ирэнгүүт, хөөе та байж байгаарай наадах чинь дутуу байна шүү, хүчинтэй, хүчингүй санал болчих гээд байна шүү гээд өгөх тэр боломж нь байна уу?

**Н.Энхболд:** Энийг Банзрагчдорж хариулчихъя. Би яг асуух гэж байсан юм. Машин нь өөрөө дутуу, илүүг нь юу яагаад тэгээд хүнд бас харуулж болохгүй шүү дээ тэр чинь тийм ээ. Нууцлаад

эзэнд нь өгөөд, дахиж нэг хураах болно. Тэр машин нь өөрөө тэрийг хийж чадаж байгаа юу гэдгийг. Түүнээс тэрийг чинь ямар ухааж гаргаж ирээд харуулдаг юм биш шүү дээ. Банзрагчдорж 3 номер.

**А.Банзрагчдорж:** Санал тоолох төхөөрөмжийн хувьд жишээ нь 10 мандаттай байхад 9-ийг нь бөглөчихвөл буцаана, 11-ийг бөглөчихвөл буцаана, яг заавал 10-ыгаа л уншина гэдгээр явна. Тэгээд энэ угаасаа буцаахдаа нөгөө нэг хажуу талынх нь энэ дэлгэц байдаг юм шүү дээ жижижсэн дэлгэц. Тэрэн дээр та дутуу бөглөсөн байна, илүү бөглөсөн байна гэдэг алдааны мессежнүүд нь ирдэг байгаа. Энэ хэрэв буцааж байгаа санал бол уншигдахгүй, тоологдохгүй. Зүгээр л буцаад гараад ирж байна л гэсэн үг. Илүү бөглөчихсөн бол саналын хуудас нь хүчингүй болгоод нэг удаа саналын хуудас нөхөж олгоно. Дутуу бөглөсөн байвал та энийгээ гүйцэд бөглө ч гэдэг юм уу тийм зааварчилгаа өгөөд явах боломжтой.

**Н.Энхболд:** Техникийн хувьд боломжтой юм байна. Хэсгийн хороо, тойргийн хороод дээр ажиллаж байгаа хүмүүс тэр хэрэв машин буцаагаад дутуу байна гээд гаргаад ирвэл тэр хүний өгсөн саналыг нууцлах асуудлыг нь бас тэнд ажиллаж байгаа улсууддаа их нарийн зааварчилгаанууд өгөх ёстой шүү. Энэ дээр энийг бас СЕХ анхаараарай. Тийм. Гишүүд асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүн байна уу? Батсуурь, Пүрэвдорж, Тогтохсүрэн. Тогтохсүрэн гишүүнээр тасаллаа. Пүрэвдорж гишүүн үгээ хэлье.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2012 онд 48 тойрогт нэр дэвшихэд АН-аас хамгийн бага саналыг би авч байсан юм, хувьтай. Тэгэхэд бол би яг тэр сонгуулийн санал тоолох машиндаа итгэж байсан. Яагаад гэвэл би тийм л санал авах ёстой гэж байсан юм. 16 онд ялахдаа, 20 онд ялахдаа би тэр сонгуулийн санал тоолох машинд итгэсэн хэвээрээ л байсан. Тэгэхээр 16



онд бол 1/3 дээр нь гар тооллого явсан. 20 онд 2/3 дээр нь явсан. Ерөнхийлөгчийн сонгуулиар 100 хувь гар тооллого явсан. Тэгээд энэ бүх тохиолдолд бол нэг ч зөрөөгүй. Монгол даяар зөрөөгүй байхгүй юу даа. Би олон газар очиж бүх бүх аймгуудаар явж уулзалт хийдэг. Тэнд очиход ийм юм болсон шүү гэж нэг ч хүн надад хэлж байгаагүй. Ховд аймагт болж байгаа сонгуулийн хэсэг хороонд бол миний хамаатан садан бас ордог. Би бас ажиглагчаар оруулдаг. Тэгэхэд эд нар бол ерөөсөө тийм юм ярьж байгаагүй. Тэгэхээр энэ бол бас нэг зарим нэгэн хүмүүсийн ялагдсандаа ярьдаг, одоо жишээ нь 2012 онд МАН-ынхан ялагдчихаад л нэг хар машиныг шатаагаад л нэг аюул болж байсан. Ялагдсан улсууд л шатаасан байхгүй юу даа. Тэгээд 20 онд, 16 онд манай намынхан ялагдсан чинь манай намын зарим нэгэн хүмүүс тийм юм яриад байдаг юм. Тэгэхээр энэ дээр бол эргэлзэх юм байхгүй гэж үзэж байгаа.

Сая ингээд Грампын сонгууль дээр Фокус ньюс агентлаг энэ *dominion voting*-ийн энэ машин санал хураалтыг луйвардчихлаа гэж хэвлэл дээр тавиад, тэрнийх нь дагуу *dominion voting* компани шүүхэд өгөөд 2,7 тэрбум доллар нэхэмжлээд, тэгээд тэрний нь 787 сая доллар дээр нь торгуулийн ял гараад, тэгээд тэрнийгээ төлөөд дууссан шүү дээ. Тийм учраас би энэ санал тоолох машинд эргэлзэх хэрэггүй. Хамгийн гол нь нөхдүүд сайн хөдөлмөрлөж, энэ ард иргэдийнхээ итгэлийг авах л хамгийн чухал гэж би хэлмээр байгаа юм. Энэ бүх зүйлийг программ хангамжтай нь шинээр бас тодорхой хэмжээний машин худалдаж авах тэр хөрөнгүүдийг бас миний шаардлагаар энэ өнгөрсөн, энэ өнгөрсөн 6 сард болсон төсвийн тодотголоор энэ асуудлыг шийдвэрлэсэн байгаа. Хамгийн гол асуудал бол тийм олонх шийдсэн, тэгээд үнэхээр МАН-ын олонх мэдээж энийг шийдэж байгаа. Санаачилгыг нь бол гаргах нь, дэвшүүлж тавих нь, олон нийтэд хүргэхийг нь бол бид нар хүргэсэн байж байгаа.

Тэгэхээр ер нь бол гол асуудал бол өөрсдөө л иргэдийнхээ итгэлийг олж авахын төлөө сайн зүтгэх хэрэгтэй. Тэгэх юм болбол ард иргэд та бүхэнд санал өгнө. Харин тэр санал, саналыг чинь энэ санал тоолох хэрэгсэл бол хамгийн сайн тоолж өгнө гэдэгт л би итгэлтэй байгаа. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Пүрэвдорж гишүүнд баярлалаа. Бас энэ хүмүүст хүрч байх ёстой мэдээлэл юм байгаа юм. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Өнөөдрийн Байнгын хорооны хурал дээр ингээд олон зүйл асуугаад байдаг нь иргэд сонгогчдыг адил тэгш мэдээлэлтэй, нэр дэвшиж байгаа, санал өгч байгаа хүмүүсийг адил тэгш мэдээлэлтэй болгох, бүрхэг зүйлийг мэдээлэлжүүлэх зорилгоор ингэж асуугаад байгаа гэдгийг бас ойлгох нь зөв байх. Хамгийн гол сонгуулийн хороонд нэг захиж хэлэх зүйл байна. Жишээлбэл мандатын тоотой ижил хэмжээний саналыг л машинд оруулдаг л энэ зүйл дээрээ л онцгой анхаарах хэрэгтэй. Жишээлбэл 10 мандаттай байвал 11-ийг зурчихсан байвал та илүү зурсан байна хүчингүй болгож нөгөө хүнд боломж олгох, 10 мандаттай тойрогт 9-ийг юм уу, 8-ыг юм уу, 6-г зурсан байвал та дутуу зурсан байна гээд. Тэгээд нууцлалыг нь хангах ёстой л доо. Тэгэхгүй бол маш олон хүмүүсийн асар их хөдөлмөр зүтгэлээр цаг нараа гаргаж сурталчилсан сурталчилгаа, бодлого, техник үйл ажиллагаанаас болж сонгууль биш болох ийм зарчим руу орно, зарчим руу орно.

Тэгэхгүйгээр юу гэдэг юм хэдэн ч мянган хүн 1-ээр дутуу юм уу, 2-оор дутуу зурчих юм билээ. Хэдэн ч мянган хүн 1-ээр юм уу, 2-оор илүү зурчих юм билээ. Энэ болгоноос болж нэр дэвшилтийн төр барих эрх ч солигдох боломжтой байдаг. Өмнөх 8 сонгуулийн үр дүнгээр харж байхад 96 онд Сүхбаатар аймгийн Баруун-Урт хот



дээр 17, 14 гээд 1 суудлаар ялж байхад, ялсан 1 суудлынх нь хүн 1 хүнээр ялж байсан, 1 хүнээр. Тэгэхээр 1 хүн төр барих эрхийг олгож болдог байхгүй юу. Тэгэхээр энэ тохиолдлыг СЕХ яг энэ техникийн нөхцөлөөрөө хангаж өгөх юм бол сая Пүрэвдорж гишүүн бол танай олон талын зүйлүүдээр сайшааж байна. Зөв л дөө. Би ч гэсэн тэр хар машинд итгэдэг, эргэлзэх хэрэггүй гэж хүмүүстээ хэлэх ёстой. Гэхдээ тэр сайшаагаад байгаа хар машин маань яг мандатынх нь тоогоор ижил тэнцүү хэмжээний саналыг аваад, олон, цөөнхөөр нь гаргаж өгөх ёстой гэсэн энэ саналыг 1 дүгээрт хэлж байгаа юм.

2-т нь энэ үйл ажиллагааг маш нууцын түвшинд ТЕГ, цагдаа, улсын бүртгэл, СЕХ бүгдээрээ орж ажлын хэсэг байгуулдаг гэж байна. Тэгэхээр сонгууль байгуулах, сонгууль явуулахад хүмүүс нэг л зүйлийг хүсдэг шударга ёс. Шударга ёс тогтоохын тулд бол хяналт. Тэгэхээр нэгэнт хяналт тавьж байгаа юм бол энэ ажлын хэсгээ парламентад суудалтай сөрөг хүчнээрээ ахлуулбал яасан юм бэ? Би бол тийм л санал тавих гэж байна. Хууль бус хуудуутай ямар нэгэн зүйл хийхгүй, шударга ёсыг дээдэлж байгаа гэсэн энэ л үйл ажиллагаагаа батлах, баталж байгаа, тэрэндээ чин эрмэлзэлтэй байж байгаа бол тэр ажлын хэсгийнхээ ахлагч байдаг юм уу, нарийн бичгийг парламентад суудалтай сөрөг хүчнээрээ ахлуулах л ийм л байгаа. Түрүүн ингэсэн шүү дээ хяналтын ажлын хэсэг. Тийм. Ийм саналыг хэлж байна.

**Н.Энхболд:** Тогтохсүрэн гишүүн.

**Д.Тогтохсүрэн:** Баярлалаа. Энэ сонгуулийн автоматжуулсан системийг техникийг Монголчууд ашиглаад бас 4 дэх, 5 дахь ч сонгуулиа үзэж байна. 4 дэх сонгуулиа үзэж байна. Ерөнхийлөгчөө орох юм бол 5, 6 дахь ч сонгууль болж байна. Энэ аягүй дэвшилттэй зүйл л дээ. Тэгээд яах вэ өнгөрсөн жил Улсын Их Хурал хөрөнгийг нь шийдээд, техник

маань шинэчлэгдсэн, хар машин маань. Тэгээд одоо энэ 24 оны сонгуулиа зохион байгуулах гэж байна. Тэгэхээр хамгийн чухал юм бол энэ 24 оны сонгуулийг олон мандаттай бүсчилсэн тойргоор явуулахаар бид үндсэндээ тогтоод байгаа. Энд хамгийн чухал юм хар машин. Гараар тоолоход маш хүндрэлтэй. 9 мандаттай тойрог дээр 40 нэр дэвшигчийг 9 ялгана гэдэг бол маш хүндрэлтэй байхгүй юу. 2008 оны сонгууль анх удаа олон мандаттай тойрогтой явагдсан. Энэний дараа маргаан гарлаа гээд нөгөө гараар тоолоод баахан маргаан гарсан байхгүй юу. Тэгээд энэний дараа дэвшил болгож энэ техник рүү орсон. Тийм учраас бол Сонгуулийн хороо энэ техниктэй, зохион байгуулалттай холбоотой асуудал бол маш сайн хийх хэрэгтэй гэдгийг би зориуд нэгд нь хэлье гэж бодож байгаа юм.

Энэ томсгосон бүсчилсэн тойрогтой холбоотойгоор 4 санал хэлье гэж бодож байгаа. Сонгуулийн хороо зохион байгуулалт дээрээ анхаарах. 1 дүгээрт хэсгийн хороодын тоог нэмэгдүүлж, ялангуяа энэ олон хүн амтай аймгийн төв, нийслэл, олон хүн амтай сумд дээр хэсгийн хороодын тоог нэмэгдүүлж явах хэрэгтэй. Олон мандаттай учраас сонгогчид саналаа өгөхдөө нэлээн удаан процесс үргэлжилнэ. Өмнө нь 1 минутад багтдаг байсан бол одоо аягүй бол 5 минут болохыг ч үгүйсгэхгүй. Мэдээж сонгогчид харилцан адилгүй. Тийм учраас бол сонгуулийн хэсгийн хороодын тоог нэмэгдүүлэх энэ чиглэлээр бас нэг өмнө нь тооцоогүй учраас энэ чиглэлээр манай Сонгуулийн хорооныхон дахиж нэг сайн тооцож үзэх хэрэгтэй. Нэг өдөртөө багтаахын тулд яах вэ гэж. Энэ нэг зохион байгуулалтын том ажил байгаа юм.

2 дахь том ажил бол түрүүн Батсуурь гишүүн дурдаад өнгөрсөн. Сонгогчдын саналыг нөгөө сонгогчид энэ олон мандаттай үед бол ямар нэгэн

хэлбэрээр будилах юм зөндөө гарна. Тэр будилсан алдаагаа засах боломжийг олгож, нууцлал хяналтыг сайн байлгах тухай асуудал гарна. Энийгээ маш сайн хийх хэрэгтэй. Мэдээж юу гэх вэ зарим ажиглагч нар юу гэдэг юм хүний санал үзэж байна эд нар гээд юм гараад эхэлнэ шүү дээ. Тийм учраас бол энэ байдлуудыг бүгдийг нь хангах зохион байгуулалтыг сайн хийж өгөх ёстой.

3 дахь асуудал бол гар тоолоход их хүндрэл учруулна. 40 хүн нэр дэвшилээ гэж бодъё 1 тойрогт 9 ялгана шүү дээ. Тэгэхээр энэ 40 ялгана, 40 ялгана. Тийм учраас бол асар их хэмжээний хүндрэл учирна. Энэ дээр бас хүн хүч нэмэх, зохион байгуулалтыг сайжруулах юмыг анхаарах хэрэгтэй.

4 дэх асуудал болбол нөгөө энэ бүсчилсэн тойрогтой болж орж байгаатай холбогдуулаад манай Сонгуулийн хорооныхон сурталчилгааныхаа зардлыг жаахан нэмэгдүүлж, сурталчилгаа сайн хийж өгөх хэрэгтэй. Одоо бол хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сошиал медиа сайн болчихсон энэ үед болбол сурталчилгаа сайн хийх боломжтой. Саналын хуудасны асуудлыг, санал өгөх процессыг, алдаа гаргавал засах боломжийг энийг бүгдийг нь аягүй тэр сурталчилгаа их сайн хийж өгөх хэрэгтэй. Ингэж байж нөгөө сонгогчийн санал зөв тусгах энэ асуудал их чухал байгаад байгаа юм. Ийм 4 саналыг хэлье. Тэгээд хамгийн чухал юм болбол манай Сонгуулийн хороо олон жил зохион байгуулчихсан, тодорхой туршилагатай. Энэ туршилага дээрээ үндэслээд бас бид нар өмнө нь зохион байгуулж үзээгүй бүсчилсэн ийм томсгосон тойргоор явж байгаа учраас энэ дээр Сонгуулийн хорооны зохион байгуулалт их чухал шүү гэдгийг хэлье.

Гэхдээ Сонгуулийн хороонд бол нэг их хүндрэл учрахгүй. Яагаад гэхээр аймаг нь байж л байгаа. Сумд нь хэсгийн хороо нь байж л байгаа. Нөгөө олон

хэсгийн хороодоороо дамжаад юмаа хийгээд л явчихдаг. Энэ систем бол байгаа учраас өмнө нь тогтсон систем нь хэвээрээ байгаа учраас зүгээр нэмэлт болбол нэг хэсгийн хороодын тоог нэмэх, юу хар машины тоог нэмэх ч юм уу ийм асуудал гарахыг бол би үгүйсгэхгүй байх гэж бодож байгаа. Ялангуяа нийслэл дээр. Энийг бол нэлээн сайн бодож үзэх ёстой гэж бодож байна. Тэгээд энэ тогтоолын төслийг дэмжиж байна.

**Н.Энхболд:** Баярлалаа.

Тогтоолын төсөлтэй, тогтоолын төсөлтэй холбогдуулж гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураана. Зарчмын зөрүүтэй санал би танилцуулчихъя. Батсуурь гишүүн энэ чинь дараагийн асуудал дээр байна шүү дээ, тийм байна. Түрүүн би тогтоолын төслөө уншаад танилцуулчихсан. Гишүүдэд тараасан байгаа хувилаад. Ингээд сонгуульд техник, хэрэгсэл хэрэглэх тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуульд техник, хэрэгсэл хэрэглэх тухай тогтоолын төслийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт. Санал хураалтад 14 гишүүн оролцож, 100 хувийн саналаар дэмжигдлээ. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны санал, дүгнэлтийг Аджасүрэн гишүүн танилцуулчих уу? Аджасүрэн гишүүн. Энэ асуудлыг хэлэлцэж дууслаа.

18.15 цаг

**Гурав. “Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төсвийг тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл**

Дараагийн асуудалдаа оръё. Монгод Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье. Тогтоолын төслийг Байнгын хорооноос боловсруулсан байгаа. Би

төслийн танилцуулгыг та бүхэнд уншиж танилцуулъя.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 оны 5 сарын 31-ний өдөр баталж оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал 1 танхимтай 126 гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын 78 гишүүнийг олныг төлөөлөх, 48 гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно гэж заасан бөгөөд үүнийг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг хуульчилсан байгаа. Үндсэн хуулийн дээрх заалтыг хэрэгжүүлэх үүднээс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуульд 2023 оны 6 сарын 16-ны өдөр нэмэлт, өөрчлөлт оруулж баталсан. Эдгээр өөрчлөлт, нэмэлтүүдийг баримтлаад улс орны нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн зорилтууд, хүн ам, сонгогчийн тоо, газар нутгийн байршил зэрэг хүчин зүйлүүд, Улсын Их Хуралд суудалтай болон улс төрийн бусад намуудтай зөвшилцсөн байдлуудыг харгалзан энэ тогтоолын төслийг боловсруулсан.

Тогтоолын төсөлд Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийг орон нутагт бүсчилсэн 7, нийслэл Улаанбаатарт 6, нийт 13 байхаар тусгалаа. Үүнд Архангай, Баянхонгор, Өвөрхангай аймгуудыг нэгтгэн 1 дүгээр тойрог, Говь-Алтай, Завхан, Увс, Ховд аймгуудыг нэгтгэн 2 дугаар тойрог, Баян-Өлгий аймаг 3 дугаар тойрог, Булган, Орхон, Хөвсгөл аймгуудыг нэгтгэн 4 дүгээр тойрог, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймгуудыг нэгтгэн 5 дугаар тойрог, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг нэгтгэн 6 дугаар тойрог, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь аймгуудыг нэгтгэн 7 дугаар тойрог, Баянзүрх дүүрэг 8 дугаар тойрог, Баянгол дүүрэг 9 дүгээр тойрог, Сүхбаатар, Чингэлтэй дүүргүүдийг нэгтгэн 10 дугаар тойрог, Сонгинохайрхан дүүрэг 11 дүгээр тойрог, Хан-Уул дүүрэг 12 дугаар тойрог, Багануур, Багахангай, Налайх

дүүргүүдийг нэгтгэн 13 дугаар тойрог байхаар тооцлоо.

Ингэхдээ бүсчилсэн хөгжлийн зорилтууд, сонгуулийн тойрогт хамаарах засаг захиргааны нэгж, нутаг дэвсгэрийн хувьд нэгдмэл, хилийн цэсийн хувьд зэргэлдээ байх тухай зэрэг хуулийн заалтууд, хүн ам сонгогчдын тоог харгалзан үзсэн болно. Мөн 2019, 2023 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн үзэл баримтлалыг амьдралд хэрэгжүүлэх, хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэрт байдлыг хангах, бодитой суурийг тавих, хэт төвлөрлийг бууруулах, эдийн засгийн нөөц боломжийг дунд, урт хугацааны хөгжлийн зорилтуудтай уялдуулан зохистой хуваарилж ашиглах, хөгжлийн томоохон төвүүдийг бий болгож улмаар улс орны эдийн засгийн биеэ даасан чадавх, ард түмний эв нэгдэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлэх зорилтыг тогтоолын төсөл боловсруулахдаа үндэслэл болголоо.

ТББХ-ны эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах, тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Танилцуулга, тогтоолын төслийг та бүхэнд тараасан байгаа. Би тогтоолын төслийг уншиж танилцуулъя. Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулийн тойрог байгуулах тойргийн мандатын тоо, дугаар, нутаг дэвсгэр, төвийг тогтоох тухай. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, 12.3, 12.4, 12.5 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.17 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас тогтоох нь.

1.Монгол Улсын аймгуудыг 7, нийслэлийг 6 тойрог болгож, Монгол

Улсын Их Хурлын сонгуулийн нийт 13 тойрог байгуулсугай. 2.Энэ дугаар нь яагаад яачихсан байна?

2.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрогт ноогдох мандатын тоог хавсралтаар баталсугай. Энэ тогтоолыг 2024 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй. Хавсралтыг нь танилцуулах уу, та нарт байгаа юм чинь явчих уу? Хавсралт танилцуулчихсан байгаа гишүүдэд очсон. Ингээд тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух гишүүд санал нэрээ өгье. Занданишатар, Батсуурь, Пүрэвдорж, Доржханд. Занданишатар дарга.

**Г.Занданишатар:** Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн тойргийн дугаар, нутаг дэвсгэр, төв, тойрог тогтоох, мандатын тоог тогтоож байна. Ер нь бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдаад 20 гаруй жил болоход бодитой хэрэгжээгүй. Өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулж, олон өнгө төрхтэй, олон төлөөлөлтэй ийм парламент болох зорилтыг дэвшүүлж, үүнтэй нийцүүлж энэ сонгуулийн тойргийн төв тойргийг тогтоож бүсчилж тогтоож байна. Тэгэхээр ингэснээр бүсчилсэн хөгжил хөгжих үндэс болно гэж итгэж байгаа. Дархан Сэлэнгийн район, төвийн бүс энэ хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн район гэж анх болж байсан. Дархан хот төвтэй. Орхон, Хөвсгөл, Булган, хөдөө аж ахуй, аялал жуулчлал аж үйлдвэрийн бас нэг төв болж хөгжих ёстой. Говийн бүс байна. Даланзадгад, Сайншанд аж үйлдвэрийн парк, төвийн бүсэд Хархорин хотыг байгуулах ёстой. Ингэхэд бол энэ хүн амын талаас илүү хувь нь Улаанбаатарт шавчихсан түгжирчихсэн энэ бүс нутгууд орхигдсон, хаягдсан, үндэсний аюулгүй байдал тусгаар тогтнолтой ч холбоотойгоор энэ ингэж газар нутаг хөгжлийн бодлого бүсчлэн алдагдаж байгаа явдлыг бол цэгцлэхэд энэ

сонгуулийн тойргийн бас том зорилго чиглэгдэж байгаа.

Ийм учраас энэ бүсчилсэн хөгжлийн бодлого дээрээ үндэслүүлж энэ хөгжлийн, бүсчилсэн хөгжлийн бодлого бол орон зай, газар зүйн төлөвлөлт, улс төр, эдийн засгийн хуваарилалт байдаг учраас улс төртэйгөө ингэж холбож ингэж үзэж байгаа. Гэхдээ энд нэг асуудал байгаа. Баян-Өлгий аймаг болбол Монгол Улсын аймгуудын нэг бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулийн дагуу Монгол Улс бол нэгдмэл улс, нэгдмэл нэг улс. Энэ бүсчилсэн хөгжлийн интеграци нэгдэж хөгжинө, баруун 5 аймгийн нэг хэзээ ч салж болохгүй Монгол Улсын газар нутаг дэвсгэрийн 1. Тэгэхээр ингэж салгаж байгаа нь бол ямар нэгэн байдлаар тэр тусдаа болж байгаа хэрэг биш. Баян-Өлгий аймаг бол бүсчилсэн хөгжлийн бодлого хөгжинө, дагуу хөгжинө, Үндсэн хуулийн дагуу нэгдмэл нэгдсэн бодлогоор явна. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжсийн хууль, Бүсчилсэн хөгжлийн бодлого хуулиудыг батална. Тэр дагуу интеграци зайлшгүй хамт байна. Гэхдээ ингэж тусдаа салгаж байгааг болбол цэвэр хүний эрхийн үүднээс, үндэсний цөөнхийн төлөөллийг хангахын тулд. Хэрвээ энэ баруун бүсийн нэг аймаг болоод орох юм болбол Баян-Өлгийн төлөөлөл байхгүй болчих учраас, цөөнхийн төлөөлөл хангагдахгүй учраас, жендерийн квот тогтоодог шиг энэ квот тогтоож өгч байна л гэсэн агуулга гэж ойлгож байгаа юм.

2 дугаарт энэ үндэстэн хоорондын зөрчил энэ нэг бүс дотор бол нөгөө блок voting гэдэг учраас блоклож хоорондоо хуваагддаг. Ийм юм үүсдэг эрсдэлтэй. Ийм учраас бол энэ бол ямар нэгэн байдлаар улс төрийн эрх, газар нутгийн эрх өгч байгаа асуудал огт биш бөгөөд зөвхөн үндэсний цөөнхийн эрхийг хангаж, хүндэтгэж, энэ үндэсний цөөнх болон эмэгтэйчүүдийн 30 квот, энэ квотыг хангаж байгаа шалгуур үзүүлэлт юм шүү гэж ойлгож байхгүй бол энэ



үндэсний аюулгүй байдалд эрсдэлтэй байдлаар энэ ангилан хуваарилж бие биеийгээ ялгаварлан гадуурхаж байгаа юм шиг аль эсвэл энийг хооронд нь хагаралдуулж зөрчилдүүлэх гэж байгаа юм шигээр ярьж хэлж, ашиглах ёсгүй. Энэ бол цэвэр ардчилсан парламентын үндсэн зарчим бол цөөнхийн эрхийг хүндэтгэж, олонхын саналаар таслан шийдвэрлэхэд чиглэгдэж байгаа юм. Үндсэн хуулийн агуулга ч гэсэн тэр. Ийм учраас энэ дээр бол бид бас энэ хүний эрхийн талаас нь үндэсний цөөнхийн эрхийг хүндэтгэж байгаа, сонгогдох, сонгогдох эрхийг нь хүндэтгэж байгаа гэдэг агуулгаар хандахгүй бол сонгууль маань нөгөө аймаг хоорондын тэмцэл, үндэстэн хоорондын тэмцэл зөрчилдөөн юм шиг байж болохгүй учраас тусдаа ялгадаг энэ олон улсын практик байна. Жишээлбэл Австралийн Африкентчууд байна, Шинэ Зеландын Мауричууд байна. Энэ олон үндэстний бас.../минут дуусав/

**Н.Энхболд:** Цаг нэмж авах уу? 1 минут нэмээд өгчих Занданшатар даргад.

**Г.Занданшатар:** Тийм учраас энэ агуулгыг СЕХ бас нийтэд зөв таниулж, ойлгуулах, олон улсын энэ цөөнхийн эрхийн квотын асуудлыг зөв тайлбарлах талаар бас юу хийж байна, юу хийхээр төлөвлөж байна вэ? 2 дугаарт сая ч гэсэн бас ярилаа. Энэ олон хүн дугуйлах дээр сонгогчдын боловсролыг дээшлүүлэх маш чухал. Мандатынхаа тоогоор дугуйлах ёстой, будах ёстой, будилахгүй байх ёстой. Энэ талаар юу ажил, ямар ажил хийж байна вэ гэдгийг би тодруулж асуух гэсэн юм.

**Н.Энхболд:** Дэлгэрнарэн дарга 4 номерын микрофон.

**П.Дэлгэрнарэн:** Бид сонгогчдын боловсролыг дээшлүүлэх чиглэлээр олон улсын байгууллагуудтай хамтарч ажиллаж, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн санхүүжилтийг авч, ялангуяа нийгмийн залуучууд,

залуучуудын бүлэг рүү их хандсан ийм ажлуудыг хийж байгаа. Бид нар сургагч багш нарийн үндэсний сүлжээг бий болгосон. Улсын хэмжээний аймаг, дүүрэг, нийслэлд бид нар болбол 2, 2 төрийн албан хаагчдаас сонгуулийн байгууллагад олон жил ажилласан төрийн албан хаагчдаас сонгож үндэсний сургагч багш нарыг бэлтгэж ийм сүлжээ бий болгосон. Мөн ерөнхий боловсролын сургуулиудын төгсөх ангийнхан 24 оны Улсын Их Хурлын сонгуулиар 18 өмнө, 18 насаар энэ залуучууд руу чиглэж сургалт хөтөлбөрийн ажлуудыг хэрэгжүүлж явж байгаа. 24 оны Улсын Их Хурлын сонгууль Улс төрийн намын хууль батлагдсантай холбогдуулаад 21 аймаг, 9 дүүрэгт бид нар сургалт мэдээллийн ажлуудыг бүгдийг нь зохион байгуулж хийсэн. 2 хууль батлагдаж гарсан хугацаа бол 23 оны 9 дүгээр сард батлагдсан. Тэрнээс хойш сая бид болбол энэ 12 сар хүртэлх энэ хугацаанд бүх засаг захиргааны нэгжүүддээ хүрч ажиллаж чадсан.

Гэсэн хэдий ч одоо сая гишүүдийн хэлж байгаа энэ санамжууд, хэлж байгаа энэ анхааруулгууд болбол маш чухал. Тэгээд одоо бол бид нар энэ тойрог, мандатын тоо тодорхой болсон, тэгээд сая гарсан энэ анхаарах зүйлүүдийг тодотгож хэлсэн. Энэтэй холбогдуулаад бид нар мөн бид нар энэ сонгуулийн үйл ажиллагааг товлон зарлагдаж байгаа хугацаа болбол 2 сарын 1 болно. Тэгэхээр энэ үлдэж байгаа хугацаандаа бол одоо бид нар яг энэ тодорхой болсон асуудлууд руугаа чиглүүлж ажил зохион байгуулна. Мөн бүх засаг захиргааны нэгжүүддээ хүрч ажиллах ийм ажлууд эхэллээ гэж ойлгож байна. Тэрнээс гадна бид нар шат шатын сонгуулийн байгууллагад ажиллах улсуудыгаа бид нар угаасаа бэлддэг. Цаг хугацааны хуваарь гаргаж бэлддэг. Ингээд энд болбол нийтдээ бүх шатын сонгуулийн байгууллагад 17, 8 мянган төрийн албан хаагчид байгаа. Тэр төрийн албан хаагчдынхаа сургалтыг

модулийг болбол сая Улсын Их Хурлын даргын сануулсан, сая түрүүчийн гишүүдийн хэлсэн энэ асуудлуудыг оруулж энэ модулиа бэлдэнэ гэж бид нар бодож байна. Энэнээс гадна энэ бид нар болбол цахим орчныг ашиглаж сургалтыг мэдээллийг дамжуулах, төрийн бус байгууллагууд, мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулж ажиллах, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг үр ашигтай ашиглах гээд олон төрлийн ажлуудыг бид нар зохион байгуулж явна. Хамгийн гол нь болбол энэ мандат тойргийн асуудал тогтсоны дараа болбол энд тааруулсан онцлогтой сургалтуудыг эрчимтэй явуулах шаардлагатай гэж үзэж байна. Баярлалаа.

**Н.Энхболд:** Баярлалаа. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Эхнээс нь хэдүүлээ батлаад товоо тогтчихлоо, хар машинаа сайшаачихлаа. Одоо тойрог, мандат, тойргийн төвийн асуудлуудыг ярьж байна. Энэ дээр бол зарим зүйл дээр бол хуваарилалтын шог байна. Эрх баригчид ер нь эрх барьж байгаа хүчин өмнөх 8 сонгуулийн дүрмээ өөрөө зохиож ялдаг байсан. Тэрийг Монголын ард түмэн мэдэж байгаа. Энэ удаа ихээхэн дүрмээ өөрсдөө зохиох гээд байх юм бол ард түмэн бол хилэнтэй байгаа шүү, эргэсэн арга зүй хийнэ шүү. Тийм учраас энэ юмнууд дээрээ бас анхааралтай хандах хэрэгтэй гэж ингэж үзэж байгаа юм. Жишээ нь тойргийн төв бол чухал л даа. Сонгуулийн хороо тойргийн төвүүддээ санхүү мөнгөө хуваарилна.

**Н.Энхболд:** Үгээр нь уничихъя.

**Ж.Батсуурь:** Тойргийн төв, салбар хороо, хэсгийн хороогоо хуваарилна. Түүнийг дагасан санхүүжилт явна. Ингээд 13 тойргийн хорооноос АН ганцхан байна. Энэ бол шударга бус байна. Өмнөговь л байна. 2-хон байна тэгвэл. Яахаараа хангалттай байдаг юм бэ?

**Н.Энхболд:** Танай ялсан аймаг л тэр шүү дээ.

**Ж.Батсуурь:** 13 тойргийн төвөөс 2-хон АН оруулаад ингээд. Та нар тэгдэггүй шүү дээ.

**Н.Энхболд:** Яах вэ би дараа нь тайлбараа хэлчихнэ.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ та нар яриулах юм уу, яриулахгүй юм уу? Шог юм хийчхээд тэрийгээ зүтгүүлээд байх юм хэрэг байхгүй шүү дээ. Тэр хуулийг та нар л баталсан шүү дээ. Бид нар баталсан юм уу? Тэгвэл би хууль биш гээд өөр юм асууя. Өөр юм асууя. Тэр тойргийг нь хуультай гээд. Тэр хуулийг нь та нар өөрсдөө баталсан л даа. Өнгөрсөн 8 жилд болсон бүх хуулиудыг та нар баталсан. Тэгээд бид нар үгээ хэлдэг. Байнгын хороон дээр цөөнх болдог, ажлын хэсэг дээр цөөнх болдог. Тэгээд Их Хурал дээр цөөнх болдог. Тэгээд одоо сүүлдээ бүүр үг ч хэлүүлэхгүй л болох юм байна л даа. Юуны техникийн боломж бол байна. Техникийн боломж байсаар байтал яахаараа Хан-Уул, Багануур, Багахангай, Налайхыг салгаж байгаа юм бэ тэгвэл, энд ямар хууль байгаа юм бэ? Хуулийн тайлбар өгчих тэгвэл. Тойргийн төв нь хуультай юм байя гэж бодъё. Тэгтэл баруун аймаг 10 мандаттай, Архангай, Баянхонгор, Өвөрхангай 9 мандаттай, Говь-Алтай, Завхан, Увс 10 мандаттай, Баян-Өлгий сая Занданишатар дарга тайлбарлалаа. Яс яривал юм бий. Булган, Орхон 8 мандаттай, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв 10 мандаттай, Дорнод, Сүхбаатар, Хэнтий 7 мандаттай, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Өмнөговь 7 мандаттай, Баянзүрх дангаараа 5, Баянгол 3, Сүхбаатар, Чингэлтэй 6, Сонгинохайрхан, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрханаас бага л байгаа шүү дээ. Яагаад 2, 3 гэж салгаж байгаа юм тэгвэл? Ямар хуулийн дагуу салгаж байгаа юм бэ энэ асуулыг асуучихъя.

**Н.Энхболд:** Би хариулт өгье. Батсуурь гишүүнээ та их ууртай асуусан болохоор бас хүмүүс нээрээ буруу болчихсон юм болов уу гэж бодож магадгүй, тийм. Би 1 дүгээрт тойргийн төвтэй холбоотой асуудлыг хэлчихье. Шогтоод энэ тэр гэсэн үг хэрэглэсэн болохоор. Энэ шогтоогүй шүү хуулийн дагуу л хийсэн юм гэж хэлэх гэж байгаа юм. Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 14.17-д сонгуулийн нэг тойрогт 2 ба хэд хэдэн аймаг, дүүрэг багтаж байвал аль олон сонгогчтой аймаг, дүүргийн сонгуулийн хороо нь тухайн тойрог дахь сонгуулийн зохион байгуулалтын ажлыг хариуцна гээд заачихсан байгаа юм. Тэгэхээр энэнээс өөрөөр энэ хуваарилсан тойргууд дээр болбол төвийг нь тогтоох боломж байхгүй байгаа юм. Хууль нь урьд нь бид нар хамтраад баталчихсан. Би эхлээд хариулчихъя гүйцээгээд. Бид нар хамтраад баталчихсан. Ардын нам биш, Монгол Улсын Их Хурал баталчихсан хуулийн дагуу л бид нар ярьж байгаа шүү дээ.

Түүнээс та нар баталсан, бид нарын оролцоогүй гэдэг бол утгагүй үг. Монгол Улсын төрийн эрх барих дээд байгууллага бүгдийнх нь оролцоотой. Тэгсэн зарим нь саналаа өгсөн, зарим нь эсрэг байр суурьтай байсан. Тэгэхдээ л Улсын Их Хурлын баталчихсан хууль болохоор бид нар тэрийгээ л барихаас өөр аргагүй. Ийм байгаа шүү гэдгийг хэлье. Би түрүүн танилцуулга дээрээ ярьсан. Байнгын хорооны хурал эхлэхэд ч бас хэлсэн. Энэ тойрог тогтоох асуудал болбол томоохон хөгжлийн бодлоготойгоо холбогдсон улс төрийн бодлого энэний цаана заавал явж байгаа. Тэр утгаар нь бид нар бас зөвшилцсөн. АН-тай ч зөвшилцсөн. Өнөөдөр суудалтай байгаа ХҮН намтай ч зөвшилцсөн. Улсын Их Хуралд суудалгүй зарим намуудтай ч бас зөвшилцсөн юм билээ. Ингээд энэ бүхнийг ярьж байгаад маш олон талаас нь ярьсан. Хүн амынхаа тоог харгалзаж үзсэн, онцлогуудыг нь харгалзаж үзсэн. Жишээ нь та асууж

байна. Багануур, Багахангай, Налайх гэхэд эд нар болбол бас нийслэлээс зайдуу оршиж ирсэн, хөгжлийн хэдийгээр нийслэлийн дүүрэг ч гэсэн хөгжлийн асуудлууд нь бас өөрснөө биеэ даагаад ингээд явчихдаг учраас тодорхой хэмжээгээр явдаг учраас эд нарыг ингэж онцгойлж авч үзэхээс авч үзэх нь зүйтэй л гэж үзсэн юм байна лээ. Бүгдээрээ ярилцаж байгаад л. Тэгээд энэ дээр бол урьд нь 2 мандат байсан тэрүүгээрээ л байж байгаа. Гэх мэтчилэн энэ тойргуудыг хуваарилсан.

Энэ дүүргүүд бол дотроо жижиг тойргууд байсныг томсгоод бас Улаанбаатар дотор л байгаа болохоос ерөнхийдөө бүсчилсэн маягаар харагдаж байгаа гэдгийг та бас харж байгаа байх гэж бодож байна. Арай жижиг 2 Сүхбаатар хүн амынхаа тоогоор Сүхбаатар, Чингэлтэй гээд зэргэлдээ 2 дүүргийг нэгтгэсэн. Зүгээр тооцоо ингээд хийгээд үзэхэд жишээ нь орон нутагт байгаа 7 тойргийн нэг мандатад ноогдох хүн амын тоо болбол 31-ээс 38-ын хооронд байна лээ ерөнхийдөө ойролцоо. Яг энэ хуваариар болбол нэг мандатад ноогдох нь. Улаанбаатар хот бол угаасаа нэг мандатад ноогддог хүний сонгогчийн тоо болбол өөр явж ирсэн. Одоо ч тийм байгаа. 24, 54-өөр бид нар хувааж байгаа шүү дээ. Тэгээд хүн амын тал хувь нь ноогдож байгаа Улаанбаатар хотод тэрийг нь дагуулж хуваарилна гэвэл арай ч тэнцвэргүй болно. Бид нарын зорилго болбол бүсчилсэн хөгжил, төвлөрлийг сааруулах, асуудлыг шийдэх ийм зүйлүүд ярьж байгаа учраас хуучин байсан үндсэндээ тэр суудлынх нь квотынхоо хэмжээнд л бас бүс дүүргээр нь томруулаад арай жижгүүдийг нь нэгтгээд бүсчилсэн маягаар хуваарилсан ийм л тооцоо гарсан.

Мэдээж Улаанбаатарт хуваарилагдсан нэг мандатад ноогдож байгаа хүний тоо болбол хөдөөгийнхөөс өндөр байгаа. Тэгэхээс ч өөр арга байхгүй. Ийм л тайлбар хэлэх байна даа.

Батсуурь гишүүн. Тэгээд юу яасан шүү. Таны нөгөө асууснаар Дорнод, Сүхбаатар, Хэнтий 3-аас биш ээ тийм, ингээд тооцоход болбол хамгийн олон хүнтэй нь Дорнод, Өмнөговь, Дорнод учраас Дорнодыг юу яасан. Уг нь зүгээр бид нар бодож байсан. Дунд нь байдгийн хувьд тийм ээ, Хэнтий, Дорнод 2, хоёр талд нь байгаа юм чинь Сүхбаатар дээр төв нь байсан юм билүү гээд ярьж байгаад тавьчихсан хойноо харсан чинь хууль дээр тэгээд заачихсан юм байна лээ. Тэгээд яах аргагүй Дорнод явсан. Яг энэтэй адилхан Өмнөговь аймгийг бас дундыг нь баримтлаад гэж бодож байсан. Хөвсгөл хамгийн цаанаа гарчихсан уг нь. Тэгээд энэ болбол зүгээр яг бид нар өөртөө зориулаад ч хуваарилчихсан зүйл биш, яг л хуулийнхаа дагуу тэгээд ингэж л гараад байгаа. Тийм. Батсуурь гишүүний утсыг өгье.

**Ж.Батсуурь:** Та хэд тайлбарыг ч янзын хийнэ л дээ. Тэгээд юм асуунгуут хажуугаар орж ирж ярьчихаад, тэрийг нь давж ярингуут чанга дуугаар асуугаад энэ тэр гэдгээ болих хэрэгтэй. Та нар ер нь 8 жил ер нь бүүр нэг дураараа дургиж, дунд чөмгөөрөө найгаж явж сурчихсан, бүүр ингээд 2 чих нь юм сонсохгүй болчихсон. Тэгээд л нэг юм хэлэнгүүт л урваг шарваг гээд л явчих юм. Ийм байна шүү дээ. Зөвшилцсөн гэх юм. Зөвшилцсөн юм чинь та нар хамаагүй гэж байгаа бол ер нь Байнгын хорооны хурал хийх хэрэг юу байгаа юм бэ? Та нар дарга нартай ярьчихсан, та нар дуугүй бай л гэх гээд байна л даа. Тэгээд дуугүй байгаад өгч болно хамаа алга. Тэртээ тэргүй би энийг бас ард түмэнд ойлгуулах гээд хэлээд байгаа байхгүй юу. Ер нь Байнгын хорооны хуралдаан гэдэг чинь яагаад байнгын ажиллагаа, ажиллагаатай парламентын чухал юу нь хэн, юу асууж байна вэ, хэн, юу хариулж байна вэ, гох дээгээ нь хаанаа байгаа юм, но нь хаана байгаа юм гэдгийг 2, 3 хүний ярилцааны зарчмаас ард түмэн ойлгодгоороо л асуудал байгаа юм. Тойргийг.../минут дуусав/

**Н.Энхболд:** 1 минутыг нь нэмээд өгье.

**Ж.Батсуурь:** Баян-Өлгий аймгийг Занданишатар дарга дарга сайхан тайлбарлаж байна. Тайлбарлаж байгаа бол 60, 70 мянга, 69 мянган хүнд яахаараа 3 мандат өгч байгаа юм. Энийг яаж тайлбарлах юм. Одоо бүх талаар нь ойлгогчихлоо. Гэтэл 48 мянган хүнтэй хүнд 2 тойрог өгч байна шүү дээ. Хот, хөдөөг нь ойлгож байна. Тэгэхээр зөвшилцлийн зарчим яриад байх юм. Үндсэн хуулийн шинэчлэлийг хийхэд парламентад ёстой бараг бүх намууд орж ирнэ гэж байсан. Ингээд жижиг намуудыг шилний цаанаас чихэр долоолгож байгаа гэж би олон удаа хэлж байсан. Одоо ч бичлэгт байж байгаа. Ингээд яг одоо энэ тойргийн системээр ороод ирэнгүүт жижиг намууд хэн нь ч орж ирэхгүй. Ахиад 2 дахиа хулхидаж байгаа байхгүй юу. Тэгээд ямар зөвшилцөл байдаг юм бэ? Нөгөөдүүл нь горьдоод та нарыг парламентад оруулна гэнгүүт нь нэг хууртаад л, тойргийг чинь өгнө гээд л нэг хууртаад л ингээд л явж байгаа юм. Тэгэхээр зөвшилцөл гээд.../минут дуусав/

**Н.Энхболд:** Баян-Өлгий бол ийм байна лээ. Яах вэ би түрүүн нөгөө хөдөөгийн тойргуудад байгаа нэг мандад ноогдож байгаа хүний тоо ярьсан. 31-ээс 38 орчим л байгаа. Тэгээд Баян-Өлгийн 3-д болбол нэгд нь яг 38 л таарч байгаа. Тойрог хуваадаг хамгийн гол үзүүлэлтүүд шалгууруудын нэг нь хүн амын тоо л доо. Тэгээд урьд нь бас Баян-Өлгий чинь 3 юутай яваад ирсэн. Сая Занданишатар дарга нэлээн дэлгэрэнгүй тайлсан, олон талаас нь ярилцсан юм билээ. Тийм. Илүү биш шүү дээ, одоо 3 байгаа шүү дээ, яг тэрүүгээрээ л байгаа. Дүнгээрээ 7 байгаа, 7 л байгаа. Би микрофоноо. Пүрэвдорж гишүүн.

**Б.Пүрэвдорж:** Тэгэхээр 2020 онд улс нэг тойрог гэдэг яриа гарсан юм. Тэгээд дээрээс нь пропорциональ систем ерөнхийдөө орно гэдэг ийм бас хүлээлт



Их Хурлын гишүүд байсан. Тэгээд тэрнийгээ баталж авсан. Тийм учраас энэ Монгол Улсын нийтдээ 20 аймгийн 61 бусад Ховдоос 20 аймгийн 61 сумаар явсан байна лээ. Тэгээд би энэ 24 оны төсвийг нэлээн бас анхааралтай ажигласан юм л даа. Ирэх оны, бид нар чинь мэдэх юм байхгүй. Ер нь эрх баригч нар л бүгдээрээ дураараа асуудлаа шийдвэрлэж байгаа учраас энэ тойрог яаж хуваагдах нь вэ гэдгийг би бас нэлээн ажигласан юм. Тэгээд нэлээн олон гишүүд жижиг тойрог дээр бас хөрөнгө оруулалтуудыг өөрсдийнхөө дэвших магадлал бүхий жижиг аймаг жишээ нь 3 хуваагдлаа гэхэд тойргууд дээрээ хөрөнгө оруулалтуудыг нэлээн тавиад байсан л даа. Тэгэхээр энэ ер нь жижиг болж магадгүй гэж бодсон. Өнөөдөр бүүр ингээд бүсчлээд яваад өгч байна.

Тэгэхдээ би бас нэг яг тэр төсөв ажиглаж байхад бол нэг зүйлийг ажигласан юм л даа. Увсыг Ховдтой, Говь-Алтайг Завхантай, Өвөрхангай, Булган гээд л. Дээрээс нь Дорноговийг үгүй, Дорноговийг Өмнөговьтой, Сүхбаатарыг Дорнодтой ингээд холбоод байхаар нь би нэг зүйл ерөөсөө ажиглаагүй юм байна л даа. Дэндүү хойноос нь явж байгаа юм байна. МАН бол бүх юмаа бүгдийг нь төлөвлөчихсөн, тэрнийхээ дагуу л энэ намуудын төлөөлөлтэй уулзаад л тэд нарыгаа зөвшөөрүүлэх маягаар л ажиллаж байгаа юм байна. Аль хэдэн сарын өмнө энэ бүсчилсэн тойрог хуваах тэр бүх зүйлээ бүгдийг нь төлөвлөчихсөн. Тэрнийгээ төсөв дээр тавьчихсан. Тэгээд ард түмний хөрөнгө оруулалтаар энэ бүсчилсэн тойргуудынхаа асуудлыг бид нар шийдвэрлэсэн шүү гэдэг ийм байдлаар сонгуульд оролцох гэж байгаа нь өнөөдөр тодорхой болж байна. Тэгэхдээ 1 л зүйлийг хэлье. Ер нь бол яах вэ энэ бүсчилсэн тойргийн асуудал бол зүгээр нэг хөрөнгө оруулалт тавьсан гэдгээрээ тийм ээ тэртээ тэргүй л ард түмний мөнгө. Энийг дандаа буруу зарцуулж байгаа. Тэгээд энэ бүсчилсэн тойрогтоо зориулаад бүсийн замуудыг

холбоод ингээд яваад, тэрүүгээрээ сонгуулийн санал авна гэдэг бол эндүүрэл л гэж би та нарт хэлмээр байна 1 дүгээрт.

2 дугаарт би энэ тойргоо тэд нар нэгэнт л тохирчихсон юм чинь санал хураалтаар дэмжигдээд явчих байх. Тэгэхээр би энэ нэг ийм зарчмын зөрүүтэй санал гаргах гэж төлөвлөж байгаа юм. 5 дугаар, энэ 5 дугаар хэсэгт байгаа юу Дархан-Уул, Сэлэнгэ, Төв аймаг бол арван, 9 мандаттай уул нь байсан юм. Энийг 10 болгосон байна. Гэтэл энэ 204 мянган сонгогчтой. Гэтэл уламжлалаар бол Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг бол нэлээн өндөр байдаг юм. Тэгээд 6 байсныг 5 болгож байгаа юм байна. Тийм учраас би энэ.../үг тасрав/

**Н.Энхболд:** 6, 6 шүү.

**Б.Пүрэвдорж:** 6 байгаа юм уу? Энэ дээр тэгсэн чинь 5 гээд тавьчихсан байна шүү дээ.

**Н.Энхболд:** Тэгвэл буруу юм.

**Б.Пүрэвдорж:** Уучлаарай тэгвэл. Тийм учраас би энийг Баянзүрх 273 мянган хүнтэй тийшээ 6 болгож шилжүүлэх нь зүйтэй л гэж үзэж байна. 9 мандат бол хангалттай. Тэрнийгээ 270 мянган хүнтэй Баянзүрх рүү шилжүүлсэн нь дээр гэж би та бүхэнд л хэлэх, хэлмээр байна.

**Н.Энхболд:** Болчихсон уу? Санал юм байна. Доржханд гишүүн, та санал гаргалаа шүү, асуулт асуусангүй тийм ээ?

**Т.Доржханд:** Баярлалаа. Би энэ дээр бол тов тодорхой байр суурьтай байгаа. Тэгээд манай намынхан бүүр 100 хувь байр суурьтай байгаа. Тэгээд энэ юу вэ гэхээр ХҮН нам ялах, ялагдах нь чухал биш. Манай, танай нам ялах, ялагдах нь чухал биш. Харин Монгол Улс ялах ёстой. Тэгээд ялахын тулд энэ бол маш зөв зүйл. Өнөөдөр Монгол Улсын бүх эдийн засагч

нар бол энийг алгаа ташаад дэмжиж байгаа юм. Яагаад вэ гэхээр Монгол Улс яагаад хөгжихгүй байгаа юм бэ гэдэг шалтгаан тов тодорхой. Яагаад гэвэл сонгуулийнхаа системээсээ болоод 76 жалга руу аваачаад хөрөнгөө хийчихдэг. Үр дүнд нь Монгол Улсын төсөв жил ирэх тусам алдагдалтай өртэй. Одоо ингээд л бүгдээрээ зовлонтой. Монгол Улсын төрийн компаниуд нь бүгдээрээ алдагдалтай, тэгээд л ашиг байхгүй. Тэгээд л бүгдээрээ хулгай. Өнөөдөр нүүрсний сонсгол гээд л ингээд явж байна. Ингээд энэ ингээд Монгол Улсын зовлон болчихоод байгаа юм.

Өнөөдөр ХҮН нам өнөөдөр бүх 330 сумаараа тойрч байна. Би өнөөдөр хувиараа гэхэд 110 орчим сумаар ингээд тойроод явж байна. Маш олон ингээд малчид бид нарын мах үнэгүй байна шүү дээ. Доржханд гишүүн та эдийн засагч юм бол өсгөөд өгөөч гээд, бодлогоо гаргаж өгөөч гээд. Зүүн аймгуудаар цувдайгаа жалганд хаяад байна гээд. Тэгээд яг ингээд мал ингээд нядалдаг ийм стандартын цех байхгүй болохоор арьсаа цоолчихдог. Тэгээд тэр нь ингээд хаягдаад байна гээд. Тэгээд цувдайг наашаагаа ингээд авчиръя гэхээр замын зардал 4 мянган төгрөг болчихоод байна. Гэтэл зах зээл маань мянган төгрөг. Тэгээд одоо яах юм бэ гээд. Ингээд л бүгдээрээ ингээд гацчихсан. Эдийн засаг нь гацчихсан, хөдөө орон нутаг нь гацчихсан, сум нь ингээд хоосорчихсон. Сумын иргэд нь аймаг руу, аймгийн иргэд нь хот руу, хотын иргэд нь гадагшаа. эгээд ийм байдалтай 33 жил явж ирлээ. Тэгээд энэ чинь үр дүнд нь иргэд маань бүгдээрээ банкны өртэй, ААН-үүд нь бүгдээрээ өртэй, улс орон бүгдээрээ өртэй. Бүгд гараа өргөж байна шүү дээ. Үгүй ээ тэгээд ийм болохоор танай нам ялах, манай нам ялах, миний тойрог эд нар гэдэг юм бол одоо хойшоо хаях хэрэгтэй.

ХҮН нам өнөөдөр энэ дээр бол түрүүн хэлээд байх шиг байна. Та нар алдана шүү дээ гээд. Хамаагүй ээ бид нар

нэг суудалгүй байсан ч хамаагүй. Монгол Улс хожих ёстой юм. Тэгээд ийм болохоороо энэ тойргийг томруулах ёстой юм гээд бид нар 5 бүс нутаг байх ёстой. Улаанбаатар хотоос гадна гэсэн ийм байдлаар ингээд саналаа өгсөн. Улсын Их Хуралд суудалтай улс төрийн намуудын удирдлагууд бол ярьсан. Сүүлийн 5 өдөр бид нар зогсоо зайгүй л ярилаа. Би бол энэ зарчим дээр бол хатуу байсаар байгаад л ирсэн. Харин энэ шийдвэр гарч байгаа нь бол зөв шүү. Ямар ч байсан ингээд томрох ёстой. Улс орны эрх ашиг чухал болохоос биш МАН, АН, ХҮН намын эрх ашиг чухал биш шүү. Тэгээд ийм л хав хатуу байр суурьтай байгаа. Энэ дээрээ бол байх болно. Тэгээд энэ харин тойргийг харин томруулах дээр зүгээр асуудал байгаа нь уг нь бол Улаанбаатар хот нэг тойрог явмаар байхгүй юу, тойрог байгаа юм. Гэтэл нөгөө 22 мандаттай, энэ чинь нөгөө санал авахаар аягүй процесс нь хэцүү байдаг юм гээд. Техникийн шалтгаантай л гэж яриад байгаа юм. Тэгэхээр нөгөө СЕХ-ноос асуух гээд байгаа юм нь юу вэ гээд тэгэхээр энийгээ үнэхээр 22 мандатыг ингээд авахад үнэхээр хүндрэл байна уу, байхгүй байна уу? Энийг нэг тодруулаад асуучихмаар байна.

Тэгээд АН-аас бас санал гарсан шүү удирдлагуудын уулзалтын үеэр. Тэгвэл 2 хуваачихъя 11, 11 болгоод, баруун, зүүн гээд Улаанбаатар хотыг 2 бүс болгочихъя гээд бас байж болно. Яагаад вэ гээд тэгэхээр зарим аймгууд нь ингээд 10 мандаттай яваад байгаа биз дээ. Тэгэхээр энэ дээр бас техникийн хувьд боломж байна уу, байхгүй байна уу гэдгийг асуучихмаар байна. Хэдийгээр бид нар зарчмын хувьд энэ дээрээ ингээд тохироод явж байгаа ч гэлээ гэсэн энийг бас нэг тодруулчихмаар байна. Иргэд олуулаа үзэж байгаа болохоор.

Дараагийн нэг зүйл нь болохоор Баян-Өлгий аймагтай холбоотой асуудал байгаа юм. Тэгээд Улсын Хурлын Хурлын даргын сая тайлбарыг бол сонслоо. Гэхдээ ХҮН намын хувьд бол Монгол Улс

нэгдмэл улс. Газар нутгийн ялгаварлал байж болохгүй. Түүнийгээ дагасан эдийн засгийн интеграцичлал байж болохгүй. Тэгээд тэр агуулгаараа энэ бүс нутгийн энэ интеграцичлалд орох тэр боломжийг нь бид нар нээж өгөх ёстой. Сумын төвдөө зам тавих биш харин тэр бүс нутгийн төв нь аймгууд руу, сумд руу холбогдсон. Энэ чинь л хөгжил шүү дээ. Энэ чинь кластер байхгүй юу. Кластер дээр суурилсан эдийн засаг ингээж явдаг. Тэгэхээр энэ Баян-Өлгий аймаг яг ийшийгээ бодитоор яаж орох юм бэ? Энэ дээр нэг хариулт авмаар байх юм. Тэгж байгаад бас саналаа хэлье. Баярлалаа.

**Н.Энхболд:** Дэлгэрнарэн дарга эхний асуултад хариулъя.

**П.Дэлгэрнарэн:** Доржханд гишүүний асуултад хариулъя. Улаанбаатар хотыг багцлаад 24 мандатыг нэг тойрог болгоод ингээд сонгууль зохион байгуулалтыг хийвэл хүндрэлтэй юу гэдэг асуудал байгаа юм. Тэгэхээр Улаанбаатар хотын хувьд болбол сонгогчдын тоо ч харьцангуй их өндөр. Тэгээд ер нь Улсын дээд шүүхэд бүртгэлтэй 37 намын болбол хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг нь газар нь болбол Улаанбаатар хот. Тэгээд яг Улаанбаатар хотыг ганцааранг нь ингээд нэг тойрог болгоод явна гэвэл 24 мандаттайг ингээд буюу эсвэл тэрний 50 хувьд хүрч нэр дэвшүүлэх намууд бол олон байгаа байх гэж үзэж байгаа. Тэгээд ингэх юм бол харин ёстой техникийн хувьд бол бас жаахан хүндрэл үүсэх ийм тооцоолол бол урьдчилсан байдлаар бол байна. Тэгэхдээ бид нар болбол яг энэ Улаанбаатар хотыг дангаар нь болгонд яах нь вэ гэдэг ийм туршилт тооцооллыг бол бүүр нарийвчилж бол хийгээгүй. Ер нь болбол энэ бол ойлгомжтой хүндрэлийн хувьд бол үүснэ гэж үзэж байна. Тийм.

**Н.Энхболд:** Баян-Өлгийтэй холбоотой асуудлыг Занданшатар дарга нэлээн сайн тайлбарласан. Баян-Өлгий аймаг дан ганцаараа биеэ даагаад

хөгжинө гэж байхгүй л дээ. Мэдээж баруун аймгуудынхаа, бүсээ бодвол баруун аймгийнхаа, баруун бүсийн аймгуудтай л хамт л хөгжинө. Энэнээс өөр арга 1 дүгээрт байхгүй, 2 дугаарт чадахгүй. Тэгэхээр энэ тэртээ тэргүй энэ бүсийн интеграцичлалд Баян-Өлгий аймаг ороод, тэгээд Монгол Улсын бусад улсуудтайгаа харьцаад явах ийм л байдлаар болох болов уу гэж бодож байна. Би түрүүн танилцуулгынхаа тайлбарт, танилцуулга дотроо, энэ бас зүгээр санамсаргүй энэ үгнүүдийг бичээгүй юм. Хот, хөдөөгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангах бодитой суурийг нь тавих, хөгжлийн томоохон төвүүд бий болгоод, тэгээд тэр нь өөрөө яваандаа эдийн засгийн биеэ даасан чадавх, үндэсний эв нэгдэл, тусгаар тогтнол, аюулгүй байдлын баталгааг дээшлүүлэх ийм зорилтуудыг үндэслэл болгож боловсрууллаа гэдгээ хэлсэн.

Тэгээд энэний цаана болбол сая миний хэлсэн би танилцуулгыг нь өөрөө бичсэн болохоор тэгж ярьж байгаа юм шүү. Баян-Өлгий аймаг ганцаараа хөгжөөд явах боломж байхгүй, баруун бүсийн аймгийн интеграцид холбогдож л таарна. Яагаад тэрийг тусад нь тавьчихав, яагаад квотыг нь үлдээчхэв гэдэг тал дээр Занданшатар дарга түрүүн нэлээн ойлгомжтой тайлбар хийчихсэн гэж бодож байна. Гишүүд асууж дууслаа. Доржханд гишүүн тодруулъя.

**Т.Доржханд:** Түрүүчийн нөгөө асуудал дээр бид нар нөгөө цахимыг ашиглаад, тэгээд нөгөө саналын байран дээр очоод ингээд зураад мөн үү, ингээд цаасаа шургуулах хүмүүс нь бол шургуулж болно, залуучууд зөндөө байна шүү дээ бүгдээрээ гар утастай байна шүү дээ. Тэгвэл гар утсан дээрээ ингээд саналаа өгөх ийм боломжийг нь ингээд нээх ажлыг хийж байна гээд түрүүн хэлсэн шүү дээ. Тэгээд тэр агуулгаараа нөгөө том ингээд 20 байна уу, 11 байна уу, Улаанбаатар хотын хүн ам их байж болно. Гэхдээ л энэ нөгөө гар утас чинь

тэр ачааллыг авчих юм биш үү? Боломжтой шүү дээ. Хэрвээ ингээд нэвтрүүлчих юм бол. Гэртээ сууж байгаад л өгчихнө гэсэн үг шүү дээ энэ чинь. Тийм биз дээ? Тэгэхээрээ ингээд бид нар нэг уламжлалт байдлаараа ингээд өмнөх турилага дээрээ үндэслээд л хэцүү дээ гээд л байгаа болохоос биш уучлаарай нийт хүн амын чинь 65 хувь нь залуучууд байна шүү дээ, 35 хүртэл насны залуучуудын орон байхгүй Монголд чинь.

**Н.Энхболд:** Санал хэллээ. Баярлалаа. Санал хэлэх гишүүд байвал нэрээ өгье. Занданшатар, Батсуурь, Доржханд, Амарсайхан. Занданшатар дарга.

**Г.Занданшатар:** Түрүүн бол түрүүн бол би асуулт асуусан энэ тойргийн хуваарилалттай холбогдуулж саналаа хэлээд. Одоо санал хэлэх гэж байна. Тэгэхээр дахин давтан хэлэхэд энэ бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал бол бүсчилсэн хөгжлийн бодлого гэдэг бол эдийн засгийн интеграцилал, нутаг дэвсгэрийн хуваарилалт, тээвэр логистик, шинжлэх ухааны үндэслэлтэй хийдэг ийм дэд бүтцийн хөгжилтэй холбоотой ийм бодлого, хөгжлийн бодлого, эдийн засгийн бодлогын асуудал. Энэ бүс нутгийн интеграцилалаас ямар нэгэн юм салах ёсгүй. Тийм учраас бүс нутгийн хөгжлийн бодлогод зайлигүй байх ёстой. Ер нь би бол энэ сонгуулийн тогтолцооны нэг давуу талыг Дархан, Эрдэнэт, улсын чанартай хотууд, энэ Хархорин одоо ингээд хотууд 5 төв бий болгож хөгжихөд Улаанбаатарын түгжрэл бол ирэх 4 жилд эрс буурна гэдэгт итгэлтэй байгаа. Үгүй ядаж Улаанбаатарын түгжрэл, төвлөрлийг шийдвэрлэж байгаа ийм бүсчилсэн хөгжлийн бодлогоо амилуулж байгаа хэрэг гэж бодож байгаа.

Тийм учраас Бүсчилсэн хөгжлийн бодлогын баримтлалаас бол ухрах ёсгүй. Баян-Өлгий аймаг бол Монгол Улсын аймгуудын нэг бүрэлдэхүүн хэсэг. Монгол Улс Үндсэн хуулийн дагуу нэгдмэл нэг улс.

Ийм учраас миний горимын санал бол Баян-Өлгий аймаг бол баруун бүсийнхээ энэ тойргийн хуваарилалт дээр бичилт дээрээ болбол баруун бүсийн 5 аймгийн нэг мөн 2 дугаар тойрогт хамаарна. Санал өгөх sub district гэж байдаг. Санал өгөх квот нь болбол 3 гэдгээрээ тусдаа бичилт хийгээд ингээд бүс нутгийн хөгжил үзэл баримтлалын хүрээнд интеграцитай Баян-Өлгий аймаг болбол баруун 5 аймгийн хөгжлийн бодлогод явна гэсэн агуулга шингээчихсэн.

Харин сонгуулийн санал өгөх ёстой юм бол үндэсний цөөнхийн хүний эрхийг хүндэтгэх, цөөнхийн хүний эрхийг хүндэтгэх, нэг бол баруун 5 аймагтай живээд үндэсний цөөнхийн төлөөлөл парламент байхгүй болчих гээд байгаа учраас нэг бол баруун 3-тай нэгдэхээр бас бусад үндэсний өрсөлдөөн хангагдахгүй. Энэ сонгуулийн тэгш шударга өрсөлдөөний зарчим хангагдахгүй байх, тэгш бус сонголтууд бий болчих ийм боломж гараад байгаа учраас энэ блок voting гэдэг буюу энэ блок чинь үндэсний блок биш, нам хоорондын өрсөлдөөн байх энэ үндсэн зарчмыг хадгалахын тулд энэ санал өгөлтөө болбол 3 гэж тусад нь тавиад, бүс нутгийн хувьд бол 2 гэсэн ангилалдаа ороод, үндсэндээ ингээд 6 тойрогтой, хөдөөгийн 6 тойрогтой гэж бичээд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалаа үндсэндээ хадгалж байгаа. Тэгэхдээ санал хураалтын системээ энэчээнээ 2.1 гэдэг ч юм уу дэд дугаарлаад явах бололцоо байдаг юм болов уу? 2-ын дэд хэсгээр. Ийм зарчмын зөрүүтэй саналаар санал хураалгаж болж байна уу гэж л ийм санал байгаа.

Энэ сонгуулийн хууль бусад юмтай яаж нийлэх юм бол доо. Дэлгэрнаран дарга энэ дээр хариу хэлэх үү? Би болбол одоогийн мөрдөж байгаа хуулиуд дээр яг ингэж тусгайлан яахад төвөгтэй л болов уу гэж бодоод байна. Хэн хэлэх вэ? Бат-Эрдэнэ.



**Д.Бат-Эрдэнэ:** Занданишатар даргын асуултад хариулъя. Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулиар болбол Улсын Их Хурал 2 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө тойрог, тойрогт ноогдох мандатын тоог тогтооно л гэж хуульчилсан. Тэрнээс тойрог хэдэн мандаттай байх вэ? Мандат дотроо 2 тусдаа байх уу, үгүй юү гэдгийг болбол шийдвэрлэх, тогтоох бүрэн эрх нь Их Хуралд байгаа. Хуулиар бол ямар нэгэн шууд хязгаарласан хориглосон зүйл бол байхгүй.

**Н.Энхболд:** Ингэж болж байгаа юм даргаа. Ингэж болж байна. Байхгүй, байхгүй. Энийг юу яая, үгүй ээ, үгүй Баян-Өлгий дээр чинь тусдаа санал хураалт явна шүү дээ даргаа. Биш ээ, нэгтгэгдэнэ бүсүүд болбол. Зүгээр ингэж л тодорхойлж л болох юм. Жишээ нь 1 дүгээр тойрог биш ээ, 2 дугаар тойрог, 3 дугаар тойрог болбол энэ нэг бүс гэдэг ойлголтыг л сонгуулийн тойрог хуваарилахгүйгээр нэг газар хийчихвэл ойлгомжтой болоод явчихна л гэж бодож байна. Тэрийг харин яаж хийх вэ? Тэгээд бодоодохъя. Тогтоол дээр хийж болох юм. Тогтоолын тэгье түүн дээр 4 дэх заалт болгоод нэг юу яагаадахъя. Ингэж болж байна. Жишээ нь одоо Монгол Улсын аймгуудыг 5 бүс, 7 тойрог, Улаанбаатар нийслэлийг 6 тойрог болгож гэж бичээд, бичилт дээрээ баруун бүс гэж нэг толгойны ард 7 тойргоо тусад нь бичээд түүн дотроо Баян-Өлгийгөө тусад нь бичээд явчхаж болж байна. Хөгжлийн 5 бүс гэж урьд нь. Нэр нэр өгөөд л хөгжлийн бүс. Тийм. Тэрийг нэг үзээдэхье. Яах вэ, Улаанбаатар, за. Занданишатар дарга.

**Г.Занданишатар:** 2 дахь гүйцээгээд хэлчих санаа нь болбол энэ Сонгуулийн хууль ямар нэг эргэлзээгүйгээр хэн нэгэнд ямар нэгэн давуу тал олгохгүйгээр статистикаар хамгийн тоо олон сонгогчтой нь төв байна гээд тэгчихсэнийг бол яг өөрийнхөө тойрог, өөрийнхөө аймагт л авах ёстой гэж ингэж явцуурч хэрэггүй

гишүүдээ. 2 дугаарт нь болбол энэ бүсчилсэн хөгжлийн бодлого баримтлал чинь Улаанбаатар хотын төвлөрлийг сааруулахын тулд дагуул хотуудаа бас хөгжүүлэх хэрэгтэй байна шүү дээ. Дагуул хотууд маань хаягдаад байдаг. Тэгтэл дэлхийн бүх улсуудын түгжрэлийг бууруулдаг шилдэг арга бол дагуул хот. Тийм учраас энэ эд нар чинь нэг дүүргийн биш нэг хотын статустай болчихсон ухаантай шүү дээ Багануур, Багахангай, Налайх гэдэг чинь.

3 дугаарт хүн амын тоо яриад байгаа юм. Ер нь сонгуулийн үндсэн зарчим дэлхий даяараа хүн ам, нутаг дэвсгэрийн төлөөлөл байна гэж байгаа юм. Тэгэхээр Калифорни муж 50 сая шахуу хүнтэй, Марины арлууд бол 200, 300-хан мянган хүнтэй. Тэгэхдээ сенатын 1, 1 гишүүн сонгож байгаа юм, тоо адилхан. Яагаад гэвэл тэр нутаг дэвсгэрийг төлөөлж байгаа гэсэн утгаараа төлөөлөл байгаа учраас. Австралид Тасманы арлууд хэдэн зуухан мянган хүнтэй мөртөө 12, 3 сая хүнтэй, Wales-тэй адилхан 12 гишүүн сонгодог жишээтэй. Тэгэхээр нутаг дэвсгэр гэдэг болбол бас улсын үндэс чинь газар нутаг, газар, хүн 2-ыг салгаж ойлгож болдоггүй учраас нутаг дэвсгэрийн төлөөллийг хангах зарчмаар яагаад Улаанбаатарт. Үнэн хэрэг дээрээ энэ 126 байна уу, 76 гишүүн бүгд хотод амьдардаг гишүүд шүү дээ, хотын төлөөлөл. Тийм учраас хотын төлөөлөл хүн амын тоогоороо цөөхөн байна гэдэг юм уу аль эсвэл тэр аймаг тэр, дүүрэг хүн амаараа өрсөлдөх нь болбол нутаг дэвсгэртэйгээ завал харьцуулж гарч байгаа юм.

Одоо байгаа мандатуудыг л хадгалчихсан байгаа шүү дээ. Баян-Өлгий аймгийн 3 мандатыг бууруулаад Сүхбаатарт нэмээд өгчих гэсэн санаа хэлээд байна. Тэгтэл хүн амын тоо чинь ч, нутаг дэвсгэрийн хэмжээ чинь ч гэсэн өөр байгаа байхгүй юу. Тийм учраас энийгээ бол улсын том эрх ашгаа хандаж, намын дарга нар манай өрөөнд сууж энэ бол ямарваа намын эрх ашиг

гэдгээсээ илүү улс орны эрх ашиг, энэ бүсчилсэн хөгжлийн бодлого, Улаанбаатарын түгжрэлийг бууруулах, төвлөрлийг сааруулах, цаашилаад үндэсний аюулгүй байдал, энэ Улаанбаатар улс болчих гээд эрсдэлийг задалж, бүсийн хөгжлийг дэмжих зорилгоор энэ сонгуулийн системийг сонголоо гээд баримт бичиг үйлдээд манай өрөөнд гарын үсэг зурсан. Манай намын дарга Оюун-Эрдэнийн санаачилгаар бол энэ бүсийн хөгжлийн үзэл баримтлалаа эрчимжүүлье, бодлого болгож хэрэгжүүлье. Улаанбаатар улс болоод хүн амын тал хувь нь Улаанбаатарт суурьшаад, хөдөө орон нутаг маань эзгүйрчих юм бол энэ улс орны газар нутгийн тусгаар тогтнолгүй аюулгүй байдал яах вэ гэдэг асуудалтай ч гэсэн холбогдож энэ сонгуулийн тогтолцооны зарчим гарч ирж байгаа гэж ойлгож байгаа.

Ийм учраас явцуу жижиг эрх ашиг, би, нам гэсэн бүх эрх ашгийг хойш нь тавьж, ерөөсөө л энэ улс орныхоо өмнө тулгамдаад байгаа асуудлыг бий болгож, олон улс төрийн намын төлөөлөл, 9 сонголт дотор бол маш олон өнгө орж ирнэ гэж олон улсын шинжээчид үздэг юм байна лээ. Ийм Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтөө ч амилуулсан ийм шинэ сонголт гэж үзэж байгаа учраас энэ дээр бол бид бас зөвхөн аймаг юм уу, намын өнцгөөс бас хандахгүй байхыг хүсэж байна.

**Н.Энхболд:** Бодоодохъё. Батсуурь гишүүн үгээ хэлж байя. Одоо үг хэлж байгаа тийм ээ. Батсуурь гишүүн.

**Ж.Батсуурь:** Үгүй ээ яах вэ их л сонирхолтой сонгууль болно. 9 дэх удаагийн сонгууль. Өмнө нь бид нар 8 удаа сонгууль хийж үзсэн. 8 удаагийн 6-д нь манай өнөөгийн эрх баригч нам эрх барьж байгаа. Энэ удаагийнхаас явцуу эрх ашиггүйгээр сонгууль хийе гэж байх шиг байна. Тэгэхээр өмнөх нь дандаа л явцуу эрх ашгийг хангаж байсан гэдгээ

нотолж байна л гэсэн үг л дээ. Энэ удаад хүчингүй санал гэж гарахгүй юм байна зөв үү? Хүчингүй санал гэдэг түүн дээр нэг ч санал байхгүй юм байна. Яагаад вэ гэхээр мандатаас илүү бол та уучлаарай гээд буцаагаад гараад ирэх юм байна. Мандатаас дутуу бол та уучлаарай гээд гараад ирэх юм байна. Тэгэхээр яах ч аргагүй мандатын тоотойгоо бүгдээрээ зурна гэхээр хүчингүй санал гэж гарч ирэхгүй юм байна гэж. Тэгэхээр ирц өндөр болох юм, ирц өндөр. Тэгэхээр СЕХ юунд хэсэг, тойргийн хорооны хүмүүст сургалт гэхээсээ илүүтэй иргэд 18 нас хүрснээс дээш иргэдэд ялангуяа анхлан санал өгөх гэж байгаа иргэдэд бүүр цаашилбал алслагдсан хөдөөд байдаг, цахим орчноос арай хол хөндий мөн энэ интернэт янз бүрийн зүйлтэй харьцаж үзээгүй энэ хүмүүстээ онцгой анхаарах ёстой.

Мэдээж ирц өндөр байгаад бүгдээрээ санал өгөөд, олонхын санал авсан хүмүүс бол тэгээд энэ тойрог томоос гарч ирж байгаа юм чинь гомдол тэмцэл гарахгүй байх. Сонгуулийн хорооны энэ удаагийн хариуцлага бол маш их өндөр болж байгаа. Яагаад вэ гэхээр 8 оны 7 сарын 02-ныг ахиж давтахгүй байх ийм үйлдэл хэрэгтэй. Тийм учраас явцуу эрх ашиг энэ сонгуулиас хойш байхгүй болоосой гэдэг үүднээс, шударга ёсны үүднээс, сонгууль чинь өөрөө шударга болохоор л асуудлыг яриад байгаа юм л даа. Тэгэхээр зэрэг маргахын тулд юм уу, ямар нэгэн байдлаар эсэргүүцэл илэрхийлж тэгээд байгаа зүйл бол огт байхгүй. Мандатын тоог хуваарилдаг бол дээрээс нь тойргийн тоогоор нь хуваарилах ёстой. Тойргийн төвийг хуульчилсан. Хуульчилна гэхээр бид нар 11-хнээ бүгдээрээ өргөөч хууль баталж чадахгүй учраас тэр хуульд ямар хүмүүс оруулсан байна. Ер нь бол тойрог томсох нь бол Үндсэн хуулийг хийж байхад үед тодорхой болчихсон байна гэдэг нь бол өнөөдөр харагдаж байна л даа.

Тэр үедээ бас худлаа ярьж байсан л даа тэгвэл. Энэ Үндсэн хуулийн өөрчлөлт дээр бол маш олон намууд парламентад орж ирэх боломж нь бүрдэх юм гэж яг энэ танхимд олон удаагийн хэлэлцүүлгээр хэлж, парламентад суудалгүй намуудыг горьдоож байсан. Тэр хүмүүс сонгуулийн болон эрх зүйн мэдлэг дутуугаасаа болж эрх баригчид хууртсан. Өнөөдөр би мэргэн хүн шиг хэлье. Энэ сонгуулийн үр дүнгээр тэр намууд орж ирэхгүй, бие даагч орж ирэхгүй. Нөгөө сонгуулийн ардчиллыг ярьж байсан, нөгөө Үндсэн хуулийг бид нар ярьж байхад бараг Монголд байгаа бүх намууд ороод ирэх шиг, бараг дуртай нэр дэвшсэн хүн ороод ирэх шиг л асуудлуудыг бид нар ярьж байсан. Тэнд бол явцуу эрх ашиг хангахгүйн үүднээс бид нар ийм эрх зүйн шинэчлэл хийж байгаа юм гэж ярьж байсан л даа. Тэгээд өнөөдөр явцуу эрх ашиг хангахгүйн үүднээс ийм болж байгаа юм гэж байгаа нь бол өөрөө зургаахан сарын өмнө хэлж байсан үгтэйгээ шууд эсрэг байр суурь дээрээс хандаж байгаа байхгүй юу. Тэгэхдээ ингээд л та нар батлаад л явна л даа, батлаад явна.

Тэгээд энд үг хэлээд байгаагийн шалтгаан нь ер нь ийм байдаг шүү эрх баригч нар. Үнэхээр явцуу эрх ашигаа хангаагүй өмнөх сонгуулиудыг хийж байсан бол нүүрсний хулгай, Хөгжлийн банк, автобус гээд явах байсан уу, явахгүй байсан уу? Тэгэхээр энэ тал дээр одоо төрийн өмнө хариуцлага хүлээж байгаа тангараг өргөсөн СЕХ-ныхонд бас амжилт хүсэж байна. Тэгээд одоо сонгууль өгөх хүмүүсийн асуудал, дээр нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, хөгжлийн бэрхшээлтэй. Нөгөө тэргэнцэртэй хүмүүс яах вэ? Нөгөө хараагүй хүмүүс яах вэ? Нөгөө сонсдоггүй хүмүүс яах вэ? Нөгөө тулгуур эрхтний бэрхшээлтэй хүмүүс яах вэ? Энэ зүйлийг хангаж өгөхгүй бол энэ бүх хүмүүсийн л дуу хоолой, тэр хүмүүсийн бодол сэтгэлийн олонхоор л ингэж сонгууль явагдах байх л гэсэн ийм итгэл

үнэмшилтэй байна. Тэгээд.../минут дуусав/

**Н.Энхболд:** Баярлалаа. Доржханд.

**Т.Доржханд:** Баярлалаа. Тэгэхээр би түрүүн бас хэлсэн байгаа, маш олон эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд гарна. Тогтохсүрэн гишүүнээ түр хүлээж байхгүй юу. Маш олон эдийн засгийн томоохон өөрчлөлтүүд гарна. Би цагаа авах юм уу, цаг нэмээд өгчих тэгэх үү? Бүтэн цагаа авчихъя. Би үгээ хэлчихье тэгэх үү гишүүдээ.

**Н.Энхболд:** Танай ямар улс төрийн.

**Т.Доржханд:** Нэмээд өгчихье гэнэ. Тэгэхээр.../үг тасрав/

**Н.Энхболд:** Доржханд гишүүн, Тогтохсүрэн чимээгүй.

**Т.Доржханд:** Баярлалаа, уучлаарай. Би Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг амилуулах шаардлага байгаа юу гэвэл байгаа. Яагаад вэ гэхээр парламентын ардчиллыг бэхжүүлэх зорилгоор Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг хийсэн. Яагаад дэлхий ертөнц жишээ нь 2 хуваагдаад байна ардчилсан дэглэмтэй, авторитар дэглэмтэй гээд 2 хуваагдаад байна. 2 хуваагдаж байгаа үед энэнээс зогсох, эсрэгцэх тийм ээ боломж нь юу вэ гэхээр парламентын засаглал. Парламентын засаглалыг бэхжүүлж байж ардчилал чинь тогтдог юм гэдгийг бол бүх судлаачид ингээд гаргаж ирээд байна. Бүх дэлхийн түүхүүд гарч ирээд байна. Тэгээд ийм болохоороо өнөөдөр Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсэн үндсэн зорилго бол парламентын ардчиллыг бэхжүүлэх байсан. 126 гишүүнтэй, пропорциональ элементийг оруулж ирсэн. Энэ бол маш том дэвшил. Энийг харин яаж биежүүлэх юм бэ гэдэг л ийм асуудал байсан. Тэгээд энэ асуудлын

хариулт нь энэ юм. Тойрог томсгоно гэдэг бол.

Тодорхой хэлье. Жижигхэн тойрогтой байхад 2 намын систем рүү л явдаг. Дэлхий дээр 2 намын систем амжилттай явсан нэг ч түүх байхгүй шүү. Хамгийн сүүлийн сүүлчийн удаа дампуурсан 2 улс байна. Манай энэ Зүүн өмнөд Азийн нэг улс байна, дампуурчихсан 2 намын тогтолцоо. Хамгийн сүүлийн дампуурсан улс байна Грек байна дампуурчихсан. Сүүлийн 40, 50 жил 2 намын системээр явчихсан. Өнөөдөр Америк Нэгдсэн Улс байна. Өрөөрөө маш их өндөр болчихсон, бүх бүтээмжийн үзүүлэлтүүд, салбарын үзүүлэлтүүдээрээ бас ингээд нөгөө хөгжилтэй орнуудынхаа ард нь орчихсон. Энэ ингээд бодитой түүх шүү. Тэгээд үр дүнд нь юу болж байна вэ Африкийн 2 намын системтэй улсуудын дийлэнх нь ингээд хойшоо үсэрчихсэн, нэг намын системтэй дарангуйлал руу орчихсон. Тэгээд дэлхий бол ингэж өөрчлөгдөөд байгаа шүү эрхэм нөхдөө. Тэгээд ийм болохоор энийг өөрчлөх нь өөрөө Монгол Улсын ардчиллын хамгаалах, цаашаа тусгаар тогтнолыг хамгаалах ийм чухал үйл хэрэг юм. Ийм болохоор энэ аль нэгэн намын эрх ашгаас маш өндөр юм.

Энийг биежүүлэх боломж нь юу байна вэ гээд тэгэхээр өнөөдрийн энэ том тойрог байна. Том тойргийн давуу тал юу юм, эдийн засгийн давуу талыг нь хажуу тийшээ тавьчихъя. Бэлэг тарааж чадахгүй, бүгдийг нь худалдаж авч чадахгүй. Тэгээд төсвийн хөрөнгөөр угжаад нөгөө тойргоо усалдаг юм чинь одоо ингээд үр дүнгүй болчихож байгаа. Тэгээд магадгүй тойргийн нөгөө Засаг дарга нарын хувьд бол дурамжхан л байгаа байх л даа. Одоо энэ дээр чинь жинхэнэ бодлого ярьж ирнэ. Бодлогын улс төрүүд гарч ирнэ. Бодлогын парламент бий болгох энэ нөхцөл нь бий болж байгаа юм. Тэгээд ийм болохоор магадгүй өнөөдөр танигдсан, танигдаагүй хүмүүс гээд л яриад байх

шиг байна. Тэрийгээ зүгээр хажуу тийшээ хараад хаячих. Энэ өөрөө ингээд парламентыг бэхжүүлж байна гэдгээрээ агуулгаараа маш том зүйл юм байгаа юм. Үр дүнд нь яах юм институтүүд бий болох юм. Нэг хүний намууд бол биш нэгдэж байгаад институт болох тэр нөхцөл рүү нь шахаж байгаа юм. Пропорциональ элемент орж ирснээрээ тэнд, өнөөдөр энэ нэг 2, 3-хан нам биш 4, 5 нам орж ирэх боломж бололцоо гарч ирнэ. Тэгээд тойрог томорсныхоо бол үр дүнд бэлэг тараагаад биш харин айлын хаалга тогшоод явдаг ийм залуучуудын эрэн үе бас гарч ирнэ.

Ийм болохоороо улс төрийн намууд хөгжих, улс төрийн институтүүд бий болох энэ боломж бол бүрдэнэ гэж бодож байгаа. Бодлого ярьдаг, бодлогоороо мэтгэлцдэг, бодлогоо хэрэгжүүлдэг, бодлогыг санхүүжүүлдэг ийм парламент бий болно гэдэг дээр бол итгэл үнэмшил байна. Ийм болохоороо энэ асуудлыг дэмжсэн. Манай нам бол 100 хувь дэмжсэн. Энийг бас ингээд бас түлхэж авсан Ардын намын удирдлага, АН-ын удирдлагад би бас талархлаа илэрхийлмээр байх юм. Өөрсдийнхөө эрх ашгийг хойш нь тавьж байгаад улс орныхоо эрх ашгийг урдаа тавьж байна гэдэг бол сайн зүйл. Энэ дээрээ хатуу байгаарай. Оюун-Эрдэнэ ээ, Гантөмөр өө өнөөдөр та нар дарга байж болно, маргааш бол байхгүй байж болно. Гэхдээ Монгол Улс бол цаашаа байна, бид нарын үр хүүхдүүд байна. Энэ үр хүүхдийнхээ зөв тогтолцоог нь бий болгож өгөх нь бид нарын үүрэг болохоос биш өнөөдөр би ялбал яах билээ, өөрийнхөө хугацааг хэдэн жил сунгах билээ, тэгээд манай нам ялчихвал ёстой гэсэн нэг ийм байдлаа одоо боль. 33 жил гацчихаад байна бүх юм чинь.

Тэгэхээр 1 ч төгрөг зарцуулахгүйгээр шийдэх боломж нь бол энэ тогтолцооны өөрчлөлт байна. Тэгвэл тогтолцоо гэдэг нь бол тойргоо томруулах юм бол энэ ардчиллыг



бэхжүүлэх гээд байна, бид нар эрх, эрх чөлөө, үр хүүхдийн маань амьдралын тэр нийгмийг бид нар өнөөдөр хийх боломж бүрдээд байна гэсэн ийм өнцгөөр хандаж энэ намуудын удирдлагууд бол шийдвэрээ гаргасан шүү. Тэгээд энийг би зориод цохон тэмдэглэмээр байна.

Тэгээд Баян-Өлгий аймагтай холбоотой асуудал дээр бас байр суурь бол Монгол Улс нэгдмэл. Гэхдээ хүний эрх, тэр үндэсний цөөнхийн асуудлыг бид нар дэмжих ёстой гэдэг олон улсын тэр байр суурийг бол ойлгож байна. Нөгөө талдаа тэр хүмүүсийн бас боломжийг бас хязгаарлах вий гэдэг агуулгаар бид нар бас хөндөж байгаа шүү. Тэгээд тийм болохоор энэ дээрээ бүгдээрээ бас ярилцах хэрэгтэй байх. Ямар ч байсан нийтээрээ энэ өөрчлөлтөөс үр өгөөжөө авдаг байх ёстой. Ингэж байж Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт нь амжина, бэхэжнэ. Энийг л өнөөдөр Улсын Их Хуралд суудалтай байгаа 3 нам бол хийх ёстой нэр төртэйгөөр. Ямар ч байсан энэ 2 бүлгийн дарга нар бас байр суурь нэгтэй байгаад би бас талархаж байгаа. Цаашидаа ч гэсэн бид нар өөрсдийнхөө эрх ашгийг хойшоо тавьж байгаад улс орныхоо эрх ашгийг хангасан ийм том реформуудыг хийж чадна гэсэн итгэл үнэмшил байгаа шүү. Энэ парламент бол реформ хийдэг парламентаараа дуусаасай гэж хүсэж байгаа шүү. Баярлалаа.

**Н.Энхболд:** Амарсайхан гишүүн үг хэлье. Хэлж байна, хэлэх гэж байна.

**С.Амарсайхан:** Бид нар энэ 21 аймагтай, 29 тойрогтой, дээрээс нь 76 мандаттай байсан бол шинэ Үндсэн хуулиар 126 гишүүнтэй, 13 тойрогтой. Тэгээд энэ сонгуулийн бас бүсчилсэн хэлбэр лүү орж байгаа. Өнөөдрийг хүртэл бид нар нийгэм, эдийн засгийн Улаанбаатар гэдэг үндсэндээ төвлөрсөн, түгжирсэн, дээрээс нь төрөлжөөгүй эдийн засагтай ийм төвөөс нэг төвт эдийн засгаас олон төвтэй, бүсчилсэн эдийн засгийн ийм үндэсний хэмжээний

хөгжлийг бий болгох боломж бүрдэж байна гэж харж байгаа.

Бид Улаанбаатарт бүгдээрээ байна. Орон нутаг хаягдсан, тэнд дэд бүтэц, суурь үйлчилгээ, эрүүл мэнд, боловсрол, нийгмийн дэд бүтэц гээд бүгд тэнцвэргүй. Бүгдээрээ Улаанбаатар хотод шавчихсан. Тэгсэн мөртөө нөгөө талдаа байгаль орчноо бүгд орхичихсон. Улаанбаатарынхаа утааг ярьсаар байгаад шийдэж чадахгүй өнөөдөр хурчихсэн. Нөгөө талдаа 21 аймаг нь цөлжчихсэн, хуурайшчихсан, нийт улс орны хэмжээний 70 хувийн газар нутаг цөлжилтийн байдалд орчихсон. Ургамал, амьтан, байгаль, цаг уур, хөдөө аж ахуй, газар тариалан гээд. Энэнээс салах цорын ганц зам. Өөрөөр хэлэх юм болбол бүс нутгийн тэнцвэртэй хөгжлийг хангах, бүс нутгийн эдийн засгийг төрөлжүүлэх, бид нарын хүссэн, хүсээгүй амь амьдралтай холбоотой энэ байгаль орчин, ногоон хөгжил, уур амьсгалын асуудлуудаа яг бүс бүсдээ бие сэтгэлээрээ мэдэрч шийдвэрлэх, ингээд хоорондоо эрүүл эдийн засгаар өрсөлдөх боломж нөхцөл болбол үйлдвэр талаасаа ч тэр каластрын чиглэлээр, эрчим хүч, ногоон хөгжил, сэргээгдэх эрчим хүч нь ч байна уу, үндэсний хэмжээний дэд бүтцүүд ч байна уу эд нар бүгдээрээ ингэж явж байж хөгжинө.

Бид одоо яг өнгөрсөн хугацаанд болбол 30 жил гэж ярьдаг. Нутаг ус, жалга дов, сум дүүрэг, бодлого тодорхойлдог, хууль баталдаг, хяналтаа тавьдаг Улсын Их Хурлын гишүүд өнөөдөр бодитой үнэн болбол хороон Засаг дарга, дүүргийн Засаг дарга хийдэг хог яриад явж байгаа, хогийн машин шийдвэрлээд явж байгаа. Иргэдийн хурлын Төлөөлөгчдийн хийх ёстой тэр гэрэл чийдэн, худаг усыг хийгээд явж байгаа. Ингэж явсаар байтал нөгөө улсаа бүтнээр нь харж, эдийн засгаа төрөлжүүлж, агуулгаар нь шийдвэрлэх энэ асуудлуудаа орхигдуулчихсан. Ийм байдалтай.

Тэгээд эцэст нь дөрвөн уулынхаа дунд бүгдээрээ бие бие рүүгээ хөлөө жийлцээд, улс төржсөөд, шийдсэн дорвитой асуудал байхгүй, тодорхой гарц шийдэл байхгүй. Дороо хий эргэсээр байгаад ийм байдалд хүрч байгаа юм. Тийм учраас өнөөдрийн энэ орж ирж байгаа тойрог, бүсчилсэн хөгжлийн асуудал, нэг аймгийн, нэг сумын жалга довын үзэл явцуу байдлаас Монголчуудыг гаргана. Нэг намын тэр битгий хэл, улс төрийн сонирхол төвлөрлөөс энэ улс орныг ангижруулна. Цаашилаад зөвхөн хэдэн улс төрийн хүрээнийхэн биш нийгэм, эдийн засгийн салбарын эрдэмтэн судлаачид, мэргэжилтнүүд судалгаа тооцоотой асуудалд хандах, тэгээд тойрог, дүүрэг дотроо хөгжихгүй, хог шорооны ахуйн асуудлуудаа ярьсаар байгаад бүгд тэрэндээ живдэг биш харин бүс бүсээрээ жинхэнэ бүс нутгийн онцлогтой эдийн засгийг төрөлжүүлэх, хөгжүүлэх ийм боломж энэ хуулиар, энэ тогтолцоогоор бий болж байна гэж харж байгаа юм.

Түүрүүн тэр Налайх, Багануурын асуудал яриад байсан. Улаанбаатар хот үндсэндээ нийслэлийн 9 дүүрэг алслагдсан 3 дүүрэг гээд 2 дүүрэг нь Төв аймгийн нутаг дэвсгэр дээр байна. Багануур, Багахангай, Налайх, яг Улаанбаатар хотын өмнө тулгамдсан энэ төвлөрөл бөглөрлийг сааруулахын тулд энэ 3 хот дүүргийг бүсчилсэн маягаар хөгжүүлж байж бид энэ үйлдвэрлэл үйлчилгээ, аялал жуулчлал, ингээд зүүн бүсийн ори, гарц болсон үйлдвэрлэл үйлчилгээ, эдийн засгийн төрөлжсөн хот тосгоны бүсчилсэн хөгжлийн асуудлуудаа ярих, тэгэхийн тулд энэ зайлиггүй энэ тогтолцоогоороо байх ёстой байгаа юм. Түүнээс биш энэ дээр ямар нэгэн байдлаар нэгийг нь бүсчлээд нөгөөхийг нь орхиод байгаа асуудал байхгүй гэдгийг манай гишүүд бас үндсэндээ ойлгож байгаа байх. Тэгэхээр энэ тогтолцоо цаашаа яваад, харин цаашилаад болбол нийслэл нэг тойрог болох ёстой явж, явж, бүүр улс

нэг тойрог болох ёстой жинхэнэ пропорциональ чиглэл рүүгээ.

**Н.Энхболд:** Тогтохсүрэн гишүүн. Гишүүд үг хэлж дууслаа. Ийм яах вэ Баян-Өлгийн асуудлыг бол бүгдээрээ ойлгож байгаа. Энэ уг нь Занданишатар дарга өөрөө түрүүн их ойлгомжтой сайн тайлбарласан гэж би бодоод байх юм. Тэгээд одоо дахиад энийгээ өөрчлөөд нэг тойрог дотор 2 төвтэй, тусдаа, тусдаа мандаттай тийм юм болчих гээд байна л даа. Тэгэхээр яг хууль дээр тэр нь зохицуулалт байхгүй байдаг. Ингэе би юу ч гэсэн боловсруулж орсон төслөөрөө санал хураана. Дэмжигдэхгүй болбол ер нь бүгдээрээ дэмжиж байгаа. Тэгэхдээ саяын хэлсэн шиг дотор нь ингээж эрх зүйн зохицуулалт хууль талаасаа болох нь уу, үгүй юуг нь судалж үзээд, ер нь энэ ингээд дэмжигдчихнэ гэсэн үг шүү дээ дэмжигдчихвэл. Тэгээд 1 тойрог дотор 2 төвтэй, тэгэхдээ 1 тойрог дотор тусдаа, тусдаа мандатын тоотой хэсгүүд байж болох нь уу гэдгийг эрх зүйн талаас нь, хуулийн талаас нь харж үзээд, хэрэв болно гэж үзвэл маргааш тэгж найруулаад чуулганд оруулчихъя. Болохгүй гэвэл одоогийнхоо энүүгээр явчихъя. Болж байна уу, тэгэх үү Занданишатар дарга. Занданишатар дарга.

**Г.Занданишатар:** Энэ чухал асуудал ярьж байгаа учраас Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалтайгаа нийцүүлж л энэ сонгуулийн тойрог, тогтолцоо юу товын тойргийн мандатын тоог шийдэж байгаа учраас энэ Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын үзэл санаандаа нийцүүлээд бүс гэдэг өгүүлбэр оруулсан нь дээр байх. Тэгэхгүй бол нийгэмд бүс гээд ойлголт өгчхөөд тэгээд тэрнийгээ салгаж хуваагаад байхаар чинь ард иргэд буруу ойлголцол төрөөд, бас буруу сэдэлд өдөөгөөд байгаа учраас энэ дээр бүс өмнө нь заагаад, 5 бүс байна гээд яахад хуулийн хувьд хориглосон зүйл байхгүй. Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарна. Улсын Их Хурал энэ тогтоолоо бүрэн

шийдэж болно. Тийм учраас үүгээрээ санал хураагаад шийдээд, ингээд явсан нь дээр. Түрүүн яах вэ бас тайлбар хэлчихэд Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үеэр тэгж ярьсан ч гэсэн энэ олон сонголттой мандат дээр байна шүү дээ эрх баригчид намууд биш олон сонголт би үлдээлээ. 9 хүн хүн дугуйлахад байна шүү дээ Батсуурь гишүүний яг ярьж байгаа эсрэгээр ийм тогтолцоо болдог. Доржханд гишүүн тэр 2 намтай Солонгос, Америк энэ тэрийг буруу хөгжсөөд байна ч гэж хэлэхгүй л дээ.

Тэгэхдээ тэднийх сингл нэг мандаттай нэг тойргоос сонгодог жижиг мажоритар учраас 2 нам л давамгайлдаг ийм тогтолцоонд бол. Олон мандаттай, том тойрог томсох тусмаа бусад жижиг намд илүү их боломж олгодог байхгүй юу. ХҮН нам ч бай, АН, бусад намууд ч гэсэн энэ олон сонголт бий болно. Эмэгтэйчүүд сонголт бий болно, залуучуудаа сонгоё гэнэ. 9 набороос сонгох гээд байна шүү дээ. Хоёрхон хүн тулгах биш. Ийм учраас энэ талаараа ийм дэвшилттэй уур амьсгалтай юмыг бас зөв ойлголт эхнээс нь нийгэмд өгч явахгүй бол энэ бас энэ маань бас нэг талаасаа цөөнхийн эрх ашгийг хамгаалж байх ёстой. Энэ л агуулгыг бид тодотгоод өгөхгүй болбол энд тэгж тайлбарлаад явчихгүй бол нөгөө бүс тойрог хоёроо холиод байна л даа.

**Н.Энхболд:** Саналаа хураана, саналаа хураана. Горимын санал байхгүй, тийм зүгээр одоо ийм л арга байна. Занданишатар даргаа тэр байгаа тойргуудаа бүс, бүс болгоод нэрлэх л тухай асуудал байна. Тэгээд бусад нь байдгаараа явчихъя. Үгүй ээ тойргийн төддүгээр баруун бүс. Тэгэхээр нэг бүс дээр нэр олдохгүй байна л даа. Баруун бүс, төвийн бүс, говийн бүс, зүүн бүс гэхээд, хангайн 1, хангай 2 уу? 1 хүснэгт нэмж оруулах юм байна гэж ойлголоо шүү би. Тэгээд бусад нь хэвээрээ байна. Зүгээр энэ урд нь л, урд нь л үүнийгээ бүс гээд л бичээд л оруулчихъя. Санал

хураалт явуулъя. Саяын горимоор би санал би горимын санал гаргачихлаа. Тойргуудаа бүсчилж урьд нь нэгтгэж 1 нэрлээд нэр өгөөд Хангай 1, Хангай 2 гээд, баруун хангай 1, хангай 2, төв, зүүн эсхүл төвөө ч байна уу, хангайгаа ч байна уу тийм ээ. Тэр зүгээр нэр байхгүй юу даа. Тэр зүгээр л нэр Батсуурь гишүүнээ, зүгээр нэр, санаа нь. Би энэ юугаараа хураалгалаа. Тэгээд дэмжигдвэл саяын урд нь бүс гэж бас нэг юм оруулаад, санал хураагаад явж байна. Төслөөрөө хураана, тийм. Төсөл дэмжигдэхгүй болбол урьд нь яах вэ бүсэд хуваагаад, энэ юмнуудаа өөрчлөхгүй.

Та тэгвэл саналаа бичээд өгөөрэй. Үгүй ээ, би горимын саналыг нь бичүүлж авчхаад, тэгээд уншиж өгчхөөд, эхлээд төслөөрөө хураалгасан. Занданишатар дарга тэгвэл яг тэрэн шиг нь юу яачих, бас зөв. Тэгээд би бас дараа нь л уншиъя. Тийм. Ийм байна, ойлголцох үүднээс. Занданишатар дарга энэ хэвээрээ үлдээд, Баян-Өлгий аймаг тусдаа хөгжлийн бүс биш учраас, энд, биш учраас баруун бүсийн бүрэлдэхүүн хэсэг болохыг Улсын Их Хурлын тогтоолдоо тусгаад шаардчихъя гэж байна. Энийгээ хэвээр нь үлдээгээд, тогтоол дээрээ заагаад оруулчихъя тэгэх үү? Тэгье. Заалтыг нь нэмчихье. Ойлгоцлоо. Тэр бас зөв, зөв. Хавсралтад биш тогтоол дээрээ оруулах юм байна. Тийм, тийм. Бас харгалзах ёстой зүйл байж болох юм тийм. Үгүй ээ харин сая уншихлаа шүү дээ. Тогтоолдоо энэ болбол баруун бүсийн бүрэлдэхүүн хэсэг шүү гэдгийг нь зөв томъёолоод, оруулаад, тийм ээ, 2 дугаар заалт болгоод, үгүй ээ биш ээ 3 дугаар заалт болгоод, 3 дугаар заалт болгоод энэ тогтоолыг хавсралтынх нь хамт дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт, тийм, тогтоолын заалт, заалт болгоё гэсэн. Хавсралт бол хэвээрээ үлдэнэ. 14 гишүүн санал хураалтад оролцож, 12 нь дэмжиж, 85,7 хувиар санал дэмжигдлээ. Болчихсон шүү дээ. 3 тогтоолоо гурвууланг нь хэлэлцчихлээ, 1 заалт нэмлээ тогтоол дээр. Хавсралтад өөрчлөлт ороогүй.

Өнөөдрийн Байнгын хороогоор хэлэлцэх асуудлуудыг ярьж дууслаа. Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа. Байнгын хорооны хуралдаан дууслаа. Би тогтоолыг өөрөө танилцуулчихна.

Тэрийг аятайхан томъёолоод оруулаад ир.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА



